

**Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага болж
шинэчлэгдэн зохион байгуулагдсан нь:
/1990 – 2009 он /**

Төрийн бус байгууллага болсон нь:

Монгол улсад өрнөсөн улс төр, нийгэм, эдийн засгийн ардчилсан өөрчлөлт эмэгтэйчүүдийн байгууллагыг тойроогүй юм. Шинэчлэл өөрчлөлтийг эмэгтэйчүүд дэмжин Монголын эмэгтэйчүүдийн хорооны удирдлагад хандаж намаас хараат бус болох, дотоод ардчилалыг өргөжүүлэхийг шаардсан юм. Нам, олон нийтийн байгууллагуудын бараг бүх хуучин удирдлагууд огцорч байсан 1989 оны сүүлээр Монголын эмэгтэйчүүдийн 5 дугаар их хурлаас сонгогдсон дарга орлогч, тэргүүлэгчид нөхцөл байдлыг тал талаас нь нарийвчлан судалж үзээд бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, шинэ сонголт явуулах нь зүйтэй хэмээн хорооны гишүүдийн хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн юм. Энэ шийдвэр тухайн үедээ нийгмийн бүх шатанд явагдаж байсан өөрчлөлт шинэчлэлтийг хүлээн зөвшөөрч, эмэгтэйчүүдийн байгууллагад ардчилалыг хөгжүүлэх нөхцөл бололцоог олгосон билээ.

Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд түүний 16 дугаар зүйлийн 10-т "... нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллагууд нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэж заасан. Монголын эмэгтэйчүүд Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу үзэл бодол, сонирхол, мэргэжил, оршин суугаа нутаг зэргээр эвлэлдэн нэгдэж эмэгтэйчүүдийн байгууллагуудыг байгуулан тэгш эрхтэйгээр зэрэгцэн үйл ажиллагаа явуулж эхлэв. Энэ үеэс Монгол улсад Төрийн бус байгууллага / ТББ / гэдэг нэр томъёог хэрэглэх болсон юм. Энэ нэр томъёо нь NGO / non governmental organization / гэдэг англи үгийг Монгол хэлнээ буулган хэрэглэсэн хэрэг байв. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих эхний жилүүдэд НҮБ-ын салбарын болон төрөлжсөн байгууллагууд, олон улсын, бүсийн эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөгчид Монголд ирж эмэгтэйчүүдийн ТББ-ын талаар олон удаа сургалт семинар зохион байгуулж байлаа. ТББ гэдэг үг Монгол улсад 1996 оноос хойш албан ёсоор хэрэглэгдэх болсон билээ. Бээжин хотноо 1995 онд хуралдсан Дэлхийн эмэгтэйчүүдийн 4-р бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын засгийн газраас "Эмэгтэйчүүд - нийгмийн хөгжилд" Чуулганыг 1996 оны 3 дугаар сард зохион байгуулж "Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөр"-ийн төслийг төр, олон нийтийн байгууллагын төлөөлөгчдөөр хэлэлцүүлэн зөвшилцсөний үндсэн дээр Монгол улсын засгийн газар баталсан бөгөөд энэ Чуулганы илтгэл болон түүнээс гарсан баримт бичигт ТББ гэдэг үг орсноор албан ёсоор хэрэглэгдэх болсон юм. Улмаар "Төрийн бус байгууллагуудын тухай" хууль 1997 онд батлагдсанаар ТББ гэдэг үг хуулиар баталгаажсан бөгөөд энэ хууль ТББ-ын эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Одоо Монгол улсад 70 шахам, тэдний гишүүн байгууллагуудыг хамруулбал 1000 гаруй эмэгтэйчүүдийн ТББ мөр зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улсад улс төрийн олон намын систем, өмчийн олон хэвшил зэрэгцэн орших болсон шинэ нөхцөл байдлыг Монголын эмэгтэйчүүдийн хороо мэдэрч, нэг цул байсан байгууллага задран олон эмэгтэйчүүдийн байгууллага зэрэгцэн үйл ажиллагаагаа эхэлж байсан үед өөрийн бүтэц зохион байгуулалтаа өөрчилсөн юм.

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо байгуулагдсан нь:

Монгол улсад нийгэм улс төр, эдийн засгийн өөрчлөлт явагдаж эхэлсэн 1990 оны 1-р сард Монголын эмэгтэйчүүдийн хорооны гишүүдийн ээлжит бус хурал болж хороог холбооны зохион байгуулалтад оруулж, нэрээ өөрчлөн Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо / МЭХ / болгов. Өөрчлөн байгуулагдсан МЭХ нь 1924 онд байгуулагдсан эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагааг уламжлан хөгжүүлж ирсэн бөгөөд нутаг дэвсгэрийн болон үйл ажиллагааны

чиглэлээр эмэгтэйчүүдийн нийгмийн байдлыг дээшлүүлэх, эрх ашгийг хамгаалах үүднээс байгуулагдсан эмэгтэйчүүдийн байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн нийгэмд үйлчлэх бие даасан, аль нэг улс төрийн намын хараат бус, ашгийн бус ТББ болов.

МЭХ-ны зорилго нь үзэл бодол, нийгмийн байдал, сүсэг бишрэл, яс үндэс, хөрөнгө чинээ, албан тушаалыг үл харгалзан эмэгтэйчүүдийн эрх ашиг сонирхолыг илэрхийлэн хамгаалж, төрөөс эмэгтэйчүүдийн талаар явуулах бодлогод олон нийт, эмэгтэйчүүдийн санал бодлыг тусгах, хэрэгжүүлэхэд гишүүн байгууллагуудын хүчийг чиглүүлэн хамтарч ажиллахад оршино.

МЭХ дараах зүйлд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:

- эмэгтэйчүүд, эхчүүд, охидын нийгэм, гэр бүлд гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь, бие сэтгэл зүйн онцлогтой холбогдсон асуудлыг судлах, шийдвэрлүүлэхэд идэвхтэй оролцох,
- хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулахын төлөө эмэгтэйчүүдийн идэвх, санаачилгыг өрнүүлэх, тэдний хөдөлмөр ахуйн нөхцөл, харилцааны соёлыг дээшлүүлэх,
- эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах,
- гэр бүлийг хөгжүүлэх талаар төрөөс явуулж буй бодлогыг хэрэгжүүлэхэд идэвхтэй туслах,
- эмэгтэйчүүдэд мэдээлэл хүргэх, сургалт сурталчилгаа явуулах,
- эмэгтэйчүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих, ажлын байр бий болгох, орлого нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэн жижиг зээл олгох,
- соёлын болон ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний сургалт зохион байгуулах,
- хүрээлэн буй орчноо хамгаалах,
- эмэгтэйчүүдийн тэгш эрх, хөгжлийн асуудлаар олон улсын байгууллага, дэлхийн болон бүс нутаг, үндэсний эмэгтэйчүүдийн бусад хөдөлгөөн, байгууллагатай холбоо харилцаагаа өргөжүүлж, үр ашигтай хамтын ажиллагаа явуулах,
- олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтарсан төслүүдийг төв ба гишүүн байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлэх,
- гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа, санаачилгыг дэмжиж эрх ашгийг нь хамгаалах ба тэдгээрийн удирдах боловсон хүчнийг чадваржуулахад анхаарч дэмжлэг үзүүлэх.,
- бүх шатны шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөлийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ...

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Хөгжлийн хөтөлбөрийн газар, Хүүхдийн сан, Хүн амын сан, Хүнс хөдөө аж ахуйг хөгжүүлэх сан, Нийгэм эдийн засгийн комисс, Европын холбооны ТАСИС хөтөлбөр, Азийн хөгжлийн банк, Ази номхон далайн бүсийн Эмэгтэйчүүдийн хөгжлийн төв, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Австрали, Голланди, Канадын засгийн газрын хөгжлийн хөтөлбөр, Японы “Солонго” нийгэмлэг, ХБНГУ-ын “Мезирор” ТББ, Италийн APS ТББ зэрэг байгууллагууд туслалцаа үзүүлж, эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд чиглэгдсэн олон төслийг хэрэгжүүлэх боломжийг нээж өгсөн нь Монгол улсад хөгжиж буй ардчилал, зах зээлийн харилцаанд МЭХ-ны үйл ажиллагааг нийцүүлэн өөрчлөхөд чухал түлхэц болсон юм.

МЭХ нь эгнээндээ 50 гаруй гишүүн байгууллагатай, эмэгтэйчүүдэд зориулсан “Монголжингоо” сонинтой орчин үеийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн болон бэхжсэн бөгөөд Монголын эмэгтэйчүүдийн байгууллагын хөгжил дэвшил, зорилгыг илэрхийлсэн логотой болох санаачилгыг Ж.Эрдэнэчимэг 1998 онд гаргаж хийлгэсэн болно.

МЭХ-ны эрх барих дээд байгууллага болох Чуулганаар дараах эмэгтэйчүүд дарга, ерөнхийлөгчөөр сонгогдов. Үүнд:

- Д. Мөнхөө - 1990 -1992 онд
- Г. Дашаа - 1992 - 1993 онд
- Н. Гэрэлсүрэн - 1993 - 2000 онд
- Ж.Эрдэнэчимэг - 2000 оноос хойш 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байна.

Энэ хугацаанд МЭХ-ны орлогч даргаар 1990-1992 онд Г.Дашаа, 1992-1993 онд Мөнхбуянт нар томилогдон ажиллажээ. МЭХ-ны 7, 8 дугаар Чуулганаас дэд ерөнхийлөгчийг сонгож ажиллуулсан бөгөөд дэд ерөнхийлөгч нь гүйцэтгэх захирал, хэвлэлийн эрхлэгчийн үүргийг давхар гүйцэтгэж байв. Энэ үүргийг Ж Эрдэнэчимэг 1993-2000 онд хашжээ.

МЭХ-ны дүрмийн дагуу гүйцэтгэх захиралаар ерөнхийлөгчийн санал болгосон хүнийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталдаг. Гүйцэтгэх захирлаар дараах эмэгтэйчүүд томилогдож байв. Үүнд:

- 2000-2004, 2009 оноос Ш Ариунаа
- 2004-2006 онд Ж. Билэгдэмбэрэл
- 2004-2007 онд Н. Золзаяа
- 2008-2009 онд Т. Гүндэгмаа хавсран ажиллаж байв.

Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны удирдах дээд байгууллага:

Монголын эмэгтэйчүүдийн байгууллагын эрх барих удирдах байгууллага нь гишүүн байгууллагын төлөөлөгчдийн Чуулган бөгөөд 5 жилд нэг удаа хуралдаж ардчилсан зарчмаар сонгогдог болно. Чуулганаас МЭХ-ны Ерөнхий зөвлөл, Хянан Шалгах Комисс / ХШК /-ын гишүүдийг сонгоно. Ерөнхий зөвлөлийн гишүүд нь тус холбооны гишүүн байгууллагын удирдлагууд болон гишүүдээс бүрдэх ба нийт гишүүдийн 30 хүртэл хувьтай тэнцэх тооны МЭХ-ны үйл ажиллагааг дэмжигчдийг нэмж сонгож болно. МЭХ-ны Ерөнхий зөвлөл нь Чуулганы чөлөө цагт МЭХ-ны үйл ажиллагааг удирдах байгууллага юм. Ерөнхий зөвлөлийн хурлаар Удирдах зөвлөл, Ерөнхийлөгчийг сонгодог. Ерөнхий зөвлөл дүрмийн дагуу жил бүр нэгээс доошгүй удаа хуралдаж тухайн жилийнхээ ажлын тайлан, ХШК-ын дотоод хяналтын дүн, холбоонд шинэ гишүүн элсүүлэх, хасах зэргийг хэлэлцэж, гишүүн байгууллагуудын ажлыг дүгнэж, дараа жилийн зорилтоо тодорхойлдог. Ерөнхий зөвлөлийн хурлын чөлөө цагт МЭХ-ны үйл ажиллагааг Удирдах зөвлөл удирдана. Удирдах зөвлөлөөс зөвшөөрөгдсөн зарим өдөр тутмын асуудлыг МЭХ-ны Удирдах зөвлөлийн Товчооны хурлаар шийдвэрлэж болох ба Товчооны бүрэлдэхүүнд ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга нар орно.

МЭХ-ны өдөр тутмын ажлыг ерөнхийлөгч удирдан зохицуулна. МЭХ - ны шинэчилсэн дүрмээр тэргүүнийг 1993 оноос эхлэн ерөнхийлөгч гэж нэрлэх болжээ. МЭХ-ны ерөнхийлөгч тус холбооны Ерөнхий зөвлөлийн ажлын албаны гүйцэтгэх захиралын нэрийг дэвшүүлэн Удирдах зөвлөлөөр батлуулан томилдог. 1993-2000 онд Чуулганаас МЭХ-ны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг сонгож, дэд ерөнхийлөгч нь гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж байв. 2000 онд дүрэмд өөрчлөлт орсноор ерөнхийлөгчийг ерөнхий зөвлөлийн гишүүдийн хурлаар сонгож, ерөнхийлөгчийн санал болгосноор гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөл баталдаг болжээ. МЭХ-ны Удирдах зөвлөлийн хурлаар МЭХ-ны Ерөнхий зөвлөлийн Ажлын албанд ажилтан авах, халах, ажлын албаны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан төсвийг батлах зэрэг асуудлуудыг шийдвэрлэдэг юм.

МЭХ-ны Чуулган 1990- 2008 онд 5 удаа чуулжээ. МЭХ дүрмэндээ 1924 онд байгуулагдсан эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагааг уламжлан хөгжүүлнэ гэж заасан тул Чуулганаа Монголын эмэгтэйчүүдийн их хурлын дугаарыг үргэлжлүүлэн дугаарласан байдаг.

Монголын эмэгтэйчүүдийн 6 дугаар их хурал 1990 онд Засгийн газрын ордны хурлын бага танхим /одоогийн А заал/-д хуралдаж Монголын эмэгтэйчүүдийн хорооны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх тухай хорооны дарга Л. Пагмадуламын илтгэл, дүрмийг шинэчлэх, зохион байгуулалтын асуудал хэлэлцжээ. Монголын эмэгтэйчүүдийн 6-р их хурал бол тус байгууллагыг өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэсэн түүхэн ач холбогдолтой хурал болно. 1989 оны сүүлчээр эмэгтэйчүүдээс хороог өөрчлөх талаар янз бүрийн санал ирж байлаа. Зарим эмэгтэйчүүд хорооны удирдлагуудыг огцор гэж шаардаж байв. Эдгээр санал, шаардлагыг тэр үеийн Тэргүүлэгчид тал бүрээс нь шүүн хэлэлцсэний үндсэн дээр өөрсдийн саналаар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, Монголын эмэгтэйчүүдийн хороог ардчилсан зарчмаар шинэчлэн өөрчлөх боломж олгох нь зүйтэй гээд Монголын эмэгтэйчүүдийн их хурлыг

зарлан хуралдуулсан юм. Хуралд 18 аймаг, 3 хотын эмэгтэйчүүдийн төлөөлөгчид, зөвлөлийн дарга нар оролцжээ. Тус хурал Монголын эмэгтэйчүүдийн хороог Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо /МЭХ/, Монголын эмэгтэйчүүдийн төв хэвлэл болох “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийг “Гоо марал” болгон өөрчилжээ. Энэ хурал анх удаа гадны хяналт, удирдлага заавар зөвлөмжгүйгээр ардчилсан зарчмаар хуралдсан болно. Энэ хурлыг бид 6 дугаар их хурал гэж нэрлэж байгаа боловч үнэн хэрэгтээ өөрчлөлт шинэчлэлтийн анхдугаар чуулган байлаа. Хурал анх удаа төлөөлөгчдийн саналаар удирдлагаа сонгосон бөгөөд энэ үес эхлэн ардчилалын зарчим МЭХ-нд хэрэгжиж эхэлсэн гэж үзэж болно. Тус хурлаар Д.Мөнхөө Монголын эмэгтэйчүүдийн холбооны даргаар, Мөнхбуянт орлогч даргаар, Бя. Энхтуяа сэтгүүлийн эрхлэгчээр сонгогдож, Тэргүүлэгч гишүүдэд Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ж.Эрдэнэчимэг, “Сүлжмэл” ХХК-ийн захирал А.Зумаа, ХОТШБ-ны орлогч дарга Д.Ома, Улаанбаатар хотын прокурорын дарга Ж.Бямбажав, Төв аймгийн ЭЗ-ийн дарга Б.Чулуунцэцэг, “Гоо марал” сэтгүүлийн эрхлэгч Б.Энхтуяа нар оржээ. Энэ үед Эмэгтэйчүүдийн Хорооны аппарат төрийн ордонд байрлаж байсныг гаргасан байв. Мөн 1992 онд хорооны дарга Д.Мөнхөө УИХ-ын гишүүнээр сонгогдсон тул хорооны ээлжит бус бүгд хурлаас Г. Дашааг хорооны даргаар сонгожээ. Хороо хэдийгээр холбоо болон зохион байгуулагдсан хэдий ч анхан шатны зөвлөлүүд төвөөсөө удирдлага - санхүүжилтийн хамааралтай хэвээр байв. Хуралд хот, хөдөөгийн 280 төлөөлөгч оролцсон байна.

Монголын эмэгтэйчүүдийн ээлжит бус 7 дугаар чуулганыг 1993 оны 8-р сарын 24 ны өдөр Төрийн ордны их танхимд 176 төлөөлөгчтэйгээр зарлан хуралдуулав. Ээлжит бус Чуулганыг зарлан хуралдуулах, дүрэмд өөрчлөлт оруулах гол шаардлага нь төсвийн санхүүжилт бүрмөсөн зогсож холбоог цаашид хэрхэн авч явах вэ гэдэг асуудал байлаа. Чуулганд 21 аймаг, нийслэл хотын эмэгтэйчүүдийн төлөөлөгчид оролцож, эдгээр 22 үүсгэн байгуулагчийн санаачилгаар жинхэнэ бие даасан байгууллагуудын холбоо болж, анхан шатны эмэгтэйчүүдийн зөвлөлүүдийг холбооны гишүүн гэх ба холбооны удирдах дээд байгууллагыг Чуулган гэж нэрлэх болсон юм.

Чуулганаар “МЭХ-ны үйл ажиллагаа, түүнийг бие даан санхүүжүүлэх асуудал”-ын тухай МЭХ-ны дарга Г.Дашаа, “Хянан шалгах шалгах комиссын тайлангийн тухай” Н. Гэрэлсүрэн нарын илтгэл, шинэчилсэн дүрмийн төсөл, зохион байгуулалтын асуудлуудыг хэлэцэв. Тус чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат өөрийн биеэр оролцож үг хэлжээ. Тус Чуулганаас баталсан шинэ дүрмээр МЭХ-ны тэргүүнийг ерөнхийлөгч гэж нэрлэх болжээ. МЭХ-ны ерөнхийлөгчөөр Н.Гэрэлсүрэн, дэд ерөнхийлөгчөөр Ж.Эрдэнэчимэг, Удирдах зөвлөлийн гишүүдэд УИХ-ын гишүүн Д.Мөнхөө, УИХ-ын гишүүн Ж.Бямбажав, Төв аймгийн ЭЗ-ийн дарга Б.Чулуунцэцэг, Улаанбаатар хотын ЭЗ-ийн дарга П. Алтанцэцэг, “Гоо марал” сэтгүүлийн эрхлэгч Б.Энхтуяа нарыг сонгожээ. Шинээр сонгогдсон удирдлага өөрийн гэсэн ажлын байргүй, дансаа улайлгаж хоосолсон, тусламжийн бараагаа ч тараасан, хуучирсан ширээ сандлаас өөр хөрөнгөгүй байгууллагыг хүлээн авсан байна.

Монголын эмэгтэйчүүдийн 8 дугаар чуулган 1998 оны 7-р сарын 2-ны өдөр Монгол улсын Засгийн газрын ордны хурлуудын танхимд хуралдав. Чуулганд МЭХ-ны гишүүн байгууллагын 200 шахам төлөөлөгчид, УИХ-ын эмэгтэй гишүүд, МЭХ-ны зарим ахмадууд, хамтран ажилладаг төр, ТББ-ын төлөөлөгчид урилгаар оролцов.

Чуулганаар “Монголын эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлууд, МЭХ-ны цаашдын зорилтын тухай” МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн болон “Хянан шалгах комиссын тайлан” ХШК-ын дарга Д.Ома нарын илтгэл, МЭХ-ны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, зохион байгууллалтын асуудлыг тус тус хэлэлцэв. Чуулганд Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабанди илгээлт ирүүлснийг Ерөнхийлөгчийн улс төрийн зөвлөх Я. Долгоржав уншиж танилцуулав.

Тус чуулган ерөнхий зөвлөлийн дотоод ардчилалыг өргөтгөх зорилгоор ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүн байгууллагын дарга нараас гадна гишүүдийн 30 хүртэл хувьтай тэнцэх МЭХ-ны үйл ажиллагааг дэмждэг урлаг соёл, бизнес, төр, захиргааны төлөөлөлийг оруулах тухай заалтыг дүрэмд нэмж оруулав.

Чуулган зохион байгуулалтын асуудал хэлэлцэж МЭХ-ны Удирдах зөвлөлийн дарга бөгөөд ерөнхийлөгчөөр Н. Гэрэлсүрэн, дэд ерөнхийлөгч бөгөөд “Монголжин гоо” сонины эрхлэгчээр Ж.Эрдэнэчимэг, УЗ-ийн гишүүдэд Улаанбаатар хотын ЭЗ-ийн дарга П.Алтанцэцэг, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Бямбажав, Төв аймгийн ЭЗ-ийн дарга М. Булган, ҮҮХХ-ны дарга Е. Цоомоо, “Ургамал ЗМ” ХХК-ий менежер Циенхүү, Хүүхдийн эрхийн төвийн тэргүүн Н.Болормаа, “Эмэгтэйчүүд-хөгжил” хөдөлгөөний тэргүүн Д.Алтай, “Хатагтай инвест” ХХК-ийн захирал С.Саранцэцэг, Эмэгтэйчүүдийн сургалтын төвийн захирал Б.Чулуунцэцэг нарыг сонгожээ. Чуулганд эмэгтэйчүүдийн 120 төлөөлөгч оролцсон байдаг.

Монголын эмэгтэйчүүдийн 9 дүгээр чуулган 2003 оны 8-р сарын 9-ний өдөр “Хүүхдийн урлан бүтээх төв”-ийн хурлын танхимд 200 төлөөлөгчтэйгээр чуулав. Чуулганд төрийн бус байгууллагын 40 шахам төлөөлөгчид урилгаар оролцжээ. Чуулганд МЭХ-ны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг “Монголын эмэгтэйчүүдийн нийгмийн байдал, МЭХ-ноос ирэх 5 жилд тавих зорилтын тухай” илтгэл, Д.Ома МЭХ-ны Хянан Шалгах Хорооны тайлан илтгэлийг тус тус тавьсан ба зохион байгуулалтын асуудал хэлэлцсэн байна. МЭХ-ны Удирдах зөвлөлд 19 хүний нэр дэвшиж, П.Алтанцэцэг, Ж.Эрдэнэчимэг, Д.Сарангэрэл, Ж.Бямбажав, Н.Гэрэлсүрэн, С.Нармандах, М.Булган, С.Саранцэцэг, Ж.Маралмаа нар 87,5 – 53.6 хувийн саналаар Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдов. МЭХ-ны Ерөнхийлөгчид 5 хүний нэр дэвшсэнээс санал хурааж олонхийн санал авсан П.Алтанцэцэг, Ж.Эрдэнэчимэг нарын саналыг дахин хурааж, Ж.Эрдэнэчимэг 67.8 хувийн саналаар МЭХ-ны Ерөнхийлөгчөөр сонгогдож батлагдсан байна. Хэдийгээр холбооны дүрэмд зааснаар ерөнхийлөгчийг МЭХ-ны Ерөнхий зөвлөлийн хурлаас сонгож, Чуулганаар батлах ёстой боловч төлөөлөгчдийн саналаар Чуулганы нийт төлөөлөгчид сонгож баталжээ. МЭХ-ны ХШК-ын гишүүдэд Г.Нааранцэцэг, Д.Ома, Д.Цэрэндэжид нарыг сонгож, даргаар нь Д.Ома ажиллах болжээ. Чуулганаас МЭХ-ны ирэх 5 жилийн зорилтыг тодорхойлохдоо:

- Эмэгтэйчүүд, ялангуяа эмзэг бүлгийн болон хотын захын хороолол, алслагдсан хөдөө нутгийн иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг өргөжүүлж, ядуурлыг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд гар бие оролцох
- Нийт иргэд, эмэгтэйчүүдэд хандсан сурталчилгаа – мэдээллийг эрчимжүүлж, мэдээллийн хүрэлцээ ил тод байдлыг хөгжүүлэхэд нөлөөлөх
- Эмэгтэйчүүдийн амьдралын олон талт байдлыг тусгасан нийгмийн байдлын судалгааг гүнзгийрүүлж, ялангуяа эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцооны ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, бодлого хөтөлбөрт нөлөөлөхүйц санал дүгнэлт гаргах,
- Эмэгтэйчүүдэд чиглэсэн зээлийн үйлчилгээний хүртээмж, бизнес эрхлэх боломж нөхцөл, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар иргэд эмэгтэйчүүдийн санал бодлыг сонсох
- Эмэгтэйчүүдийг хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн аливаа хөтөлбөр, төслийн үр дүнд иргэний нийгмийн зүгээс хяналт – үнэлгээ хийх арга ажиллагааг төгөлдөржүүлж, өргөжүүлэх зорилт тавьсан байна.

МЭХ, түүний гишүүн байгууллагууд тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлж, эмэгтэйчүүдийг хөгжүүлэх олон тооны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн дараачийн чуулганаа угтсан юм.

Монголын эмэгтэйчүүдийн 10 дугаар чуулган 2008 оны 8 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотын Баянгол рестораны их танхимд чуулж, 208 төлөөлөгч оролцжээ. МЭХ-ны ерөнхийлөгч Эрдэнэчимэгийн тавьсан Монголын Эмэгтэйчүүдийн холбооны тайлан, ХШК-ын тайлан илтгэлүүдийг сонсч, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэв. Хурлын төлөөлөгчдөөс Г.Маамуу, Н.Золзаяа, Г.Улаан нарын 20 шахам хүн үг хэлж, МЭХ-ны үйл ажиллагааг сайшаан дүгнэхийн зэрэгцээ оршиж буй дутагдлыг хурцаар шүүмжилж байлаа. МЭХ-ны ерөнхийлөгчид Ж.Эрдэнэчимэг, Д.Нарантуяа нарын нэрийг дэвшүүлжээ. Чуулганаас шинээр сонгогдсон Ерөнхий зөвлөлийн анхдугаар хурлаас 98.5 хувийн саналаар МЭХ-ны ерөнхийлөгчөөр Ж.Эрдэнэчимэгийг улируулан сонгожээ. Удирдах зөвлөлийн гишүүдэд Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн хүндэт тэргүүн П.Алтанцэцэг, Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн ажилтан Ж.Бямбажав, МЭХ-ны хүндэт ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, “Онсь трейд” ХХК-ийн захирал Ж.

Маралмаа, Удирдлагын Академийн багш С.Нармандах, Төв аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга М. Булган, Монголын сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч Д.Сарангэрэл, Жендэрийн тэгш байдлын үндэсний хорооны Ажлын албаны дарга Ц.Цогзолмаа “Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд” сэтгүүлийн эрхлэгч Н.Золзаяа нарыг тус тус сонгов. Чуулганаас:

- 2009, 2012 онд болох МЭХ-ны 85 жилийн ой, Монголын эмэгтэйчүүдийн II,III нэгдсэн Чуулганыг эхчүүд, эмэгтэйчүүдийн олон нийтийн төвлөрсөн арга хэмжээ болгон зохион байгуулах
- 2008 оны орон нутгийн сонгуульд аль болох олон эмэгтэйчүүдийн нэрийг дэвшүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжиж Монголын нийгэм дэх эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх үндэс суурийг бэхжүүлэх
- МЭХ-ны байгууллагын чадавхийг улам бэхжүүлж, зах зээлийн харилцааны нөхцөлд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, нийгмийн оролцоог дээшлүүлэх менежментийг хөгжүүлэх
- Хүнсний аюулгүй байдлыг хангах ажилд бодитой хувь нэмэр оруулж, эмэгтэйчүүдийг эрүүл хүнс үйлдвэрлэх, хэрэглэх, орлого, хуримтлал бий болгох арга ажиллагаанд сургах ба тэдэнд эрүүл мэндээ хамгаалах, нийгмийн халдварт өвчнөөс сэргийлэх мэдлэг түгээж дэмлэг үзүүлэх
- Байгаль орчноо хамгаалах, ногоон байгууламж бий болгож, орчноо цэцэгжүүлэх талаар Орхон аймаг, Эрдэнэтийн УБҮ-ийн Эмэгтэйчүүдийн зөвлөлүүдийн санаачилгыг дэмжиж хөдөлгөөн өрнүүлэх зорилт дэвшүүлсэн байна.

МЭХ-ны дотоодын хяналт:

Монголын эмэгтэйчүүдийн байгууллагын дотоодын хяналтыг 1990 оноос өмнө Монголын эмэгтэйчүүдийн их хурлаас сонгогддог Хянан Шалгах Комисс гүйцэтгэж байжээ. Энэ уламжлалыг шинэ нөхцөлд үргэлжлүүлэн хэрэгжүүлж МЭХ-ны дотоод хяналтын байгууллага болох Хянан Шалгах Хороо / ХШХ / - нь МЭХ-ны Чуулганаас сонгогддог ба даргаа хорооны гишүүдийн хурлаас батлан ажиллуулж байна. Монголын эмэгтэйчүүдийн 6 дугаар их хурлаас МЭХ-ны ХШК-ын гишүүдэд АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын шагналын тасгийн дарга Н.Гэрэлсүрэн, НААҮЯ-ны хэлтсийн дарга Надмид, Сангийн яамны ажилтан Оюун, Ардын хянан шалгах хорооны улсын байцаагч Мягмар нарыг сонгожээ. Н.Гэрэлсүрэн даргатай тус комисс 1990 оноос 1993 он хүртэл ажиллахдаа холбооны “Гоо марал” сэтгүүлийн үйл ажиллагаанд гарч байсан санхүүгийн зөрчлийг илрүүлэн шийдвэрлүүлж байжээ. МЭХ-ны 7 дугаар Чуулганаар ХШХ-ын гишүүдэд “Уран бүсгүй нэгдэл”-ийн тэргүүн Б.Долгормаа, ХОТШ банкны дэд захирал Д. Ома, Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн санхүүч Г. Цэрэндэжид нарыг сонгож, Б. Долгормаа даргалах болов. Тус хороог МЭХ-ны 8 дугаар Чуулганаар улируулан сонгож, 1993-2003 онд ажилласан ба МЭХ-ноос гишүүн байгууллагуудаараа дамжуулан олгож байгаа жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж, сайжруулах талаар зөвлөмж өгч байжээ. МЭХ-ны 9 дүгээр Чуулганаас МЭХ-ны ХШХ-ны гишүүнээр Капитрон банкны ажилтан Д. Ома, Хилчин эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн Г. Наранцэцэг, Улаанбаатар хотын ЭЗ-ийн ерөнхий санхүүч Г. Цэрэндэжид нарыг сонгосон ба Д. Ома даргалах болов. Хянан шалгах хороо МЭХ-ны Ерөнхий зөвлөлийн Ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаа болон тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, өр авлагын асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлсэн байна. МЭХ-ны 10 дугаар чуулганаар байгуулагдсан ХШХ 5 гишүүнтэй болж, Ома, Янжиндулам, Ганаа, Нарантуяа, Байгалмаа нар сонгогдсон бөгөөд Д. Ома даргалах боллоо.

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо шинэ нөхцөлд үйл ажиллагаагаа явуулсан нь:

МЭХ ардчилал-зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд төрийн бус байгууллагын удирдлага - санхүүжилтийн шинэ зарчмаар ажиллахын зэрэгцээ уламжлалаа хадгалахын чухлыг ухаарч, эмэгтэйчүүдийг нийгмийн байдал, улс төрийн үзэл бодлоор нь үл ялгаварлаж, ажлын байр, орлого бий болгох, эрүүл мэндээ хамгаалах, амьдрах ухааны сургалт явуулах зэргээр

эмэгтэйчүүд харилцан бие биедээ туслах ажлыг төсөл хэрэгжүүлэх замаар зохион байгуулах боллоо.

Эмэгтэйчүүдэд зориулсан жижиг зээлийн төслийг хэрэгжүүлсэн нь: Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн тэр үеэс эхлэн эмэгтэйчүүдийн амьдралын бэрхшээл улам нэмэгдсэн билээ. Улсын өмчийн хувьчлалаар эн тэргүүнд олон эмэгтэйчүүд ажилгүй болж, улам бүр албан бус хэвшилд татагдан орж эхлэв. Нөгөө талаар ажлын байргүй болсон эрэгтэйчүүд архинд орж, бухимдлаа гэр бүлдээ гаргах болсноор эмэгтэйчүүдийн нуруун дээрх ачаа эдийн засгийн болон сэтгэл зүйн сөрөг шинжтэй болж байлаа. Эмэгтэйчүүд биеэ үнэлэх явдал ил гарч, тэдний хамрах хүрээ нэмэгдэн насанд хүрээгүй охидыг татах болсон. Нийгмийн сөрөг нөлөөллөөс тэднийг хамгаалахын тулд юуны өмнө эмэгтэйчүүдийн амьдрал ахуйг дээшлүүлэх явдал чухал болохыг мэдэрч, туслах арга замыг хайж эхэлсэн байна. МЭХ 1989 онд / дарга нь Д Мөнхөө / НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн санд хандан эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах төсөл бичиж 1990 оноос хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү төслөөр анх удаа эмэгтэйчүүдэд жижиг зээл олгож эхэлсэн юм. Эмэгтэйчүүдийн жижиг зээлийн анхны санг Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөл / дарга нь Ж Эрдэнэчимэг /, Дархан хотын ЭЗ / дарга нь П Цэнгэлсайхан / анх хариуцан хэрэгжүүлсэн байна. Жижиг зээлийн санг Улаанбаатар хотод Хоршоо банкинд байршуулан зээлдэгчид банкаар дамжуулан зээлээ авч, үндсэн зээл ба хүүгээ графикаар төлж байжээ. Энэ бол Монгол улсад анх удаа олон улсын байгууллагын санхүүжилтээр эмэгтэйчүүдийн ТББ, арилжааны банк хамтран олгосон бичил зээл юм. Зээлийн үйл ажиллагааг МУЗГ, НҮБХХ, МЭХ, Хоршоо банк гэсэн 4 талт уулзалтаар хэлэлцэн хянадаг байжээ. Хэдийгээр төсөл дууссан боловч жижиг зээлийн санг үргэлжлүүлэн ажиллуулж, 1994 онд дүгнэхэд зээлийн эргэн төлөлт 100 хувьтай байлаа. Төслийн Удирдах хороонд НҮБ-ийн бодлогоор Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв зэрэг шинээр байгуулагдсан эмэгтэйчүүдийн ТББ-уудыг оруулж байсан юм. Эдгээр байгууллагын төлөөлөгчид бас Хоршоо банкинд ажиллаж байв. Гэвч Хоршоо банк дампуурснаас банкинд байсан хөрөнгийг алдаад, эмэгтэйчүүдийн гар дээр байсан үлдэгдэл хөрөнгийг Ардын банкинд байршуулсан боловч энэ банк бас дампуурч сангийн хөрөнгийг МЭХ олж авч чадаагүй билээ. Ядуу, өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүдэд зориулсан жижиг зээлийн сан ажиллуулсан туршлага нь МЭХ-нд дараа дараагийн олон ийм төслийг хэрэгжүүлэх боломжийг олгосон юм.

НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сан, Хөгжлийн хөтөлбөр, Хүнс ХАА-н байгууллага, Ази номхон далайн бүсийн нийгэм, эдийн засгийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, ТАСИС хөтөлбөр, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах олон хөтөлбөр төслийг хэрэгжүүлж, хамтран ажиллагчаар МЭХ-г сонгож байв. Тухайлбал, Говийн эмэгтэйчүүдийн албан бус боловсролын хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах төсөл, жижиг зээлийн “микростарт” хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх төсөл зэргээс гадна олон тооны жижиг төслүүдийг хэрэгжүүлсэн юм. Эдгээр төслийн үр дүнд аймаг, хот бүрд гишүүн байгууллагуудаараа дамжуулан жижиг зээлийн сан ажиллуулж байв. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамтай хамтран 2001 онд “Жижиг зээл ба эмэгтэйчүүд” сэдэвт Үндэсний семинар зохион байгуулан эмэгтэйчүүдэд жижиг зээл олгосон 10 жилийн ажлаа дүгнэхэд 650 гаруй тогтвортой ажлын байр бий болгож, 10 000 гаруй эмэгтэйчүүдэд зээл олгосон байлаа. Үндэсний семинарын үеэр НХХЯ-ны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга Н.Аюуш “Жижиг зээлийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар төрөөс баримталж буй бодлого”, МЭХ-ны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг “Жижиг зээлийн үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн ТББ-ын оролцоо”, “Хөгжлийн алтан сан” ХХК-ийн дэд захирал Ц.Оюунжаргал “Банк бус санхүүгийн байгууллагын жижиг зээлийн үйл ажиллагаа ба цаашдын төлөв”, ЯБХГ-ын дарга С.Онон “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа жижиг зээлийн төслүүд, түүнд эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвээр тус тус илтгэл тавьж, семинарт оролцогчид хэлэлцэн зөвлөмж гаргажээ. Семинарын материалыг эмхэтгэн товхимол болгон хэвлүүлсэн байдаг. Улмаар Австралийн хөгжлийн агентлагийн тусламжтайгаар жижиг зээлийн САС

төслийг Орхон, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймгийн ЭЗ, Голландын засгийн газрын “Хөгжлийн хөтөлбөр”-ийн санхүүжилтээр КАП төслийг Дундговь, Баян-Өлгий, Увс, Архангай аймгийн ЭЗ-өөр дамжуулан хэрэгжүүлэв. Дархан цаазат газрын эмэгтэйчүүдэд туслах төслийг “Тахь” төслийн хүрээнд Төв аймгийн Алтанбулаг суманд хэрэгжүүлжээ. Мөн НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн байгууллагын тусламжтайгаар Ховд, Говь-Алтай, Дорнод аймагт хүнсний ногоо тариалах жижиг зээлийн төсөл, ХБНГУ-ын “Мезирори” ТББ-ын тусламжаар МЭХ-ны орон нутаг дахь эмэгтэйчүүдийн байгууллагуудад тоног төхөөрөмжийн жижиг зээлийн төсөл, Америкийн ТРИКЛ-АП ТББ-ын төслөөр ядуу эмэгтэйчүүдэд малын зээл олгох төслүүдийг хэрэгжүүлж гишүүн байгууллагуудынхаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн юм.

Жижиг зээлийг зөвхөн мөнгөн хэлбэрээр бус, бас гахай, хонь ямаа, оёдлын болон гоймонгийн машин, даавуу материал, ногооны үр зэрэг хэлбэрээр өгч орон нутгийн захиргаатай хамтран ядуу өрхөд ногоо тарих газар олгуулж байлаа. Архангай аймагт хамгийн анхны үсчин-гоо сайхны салон байгуулсан, 12 000 төгрөгний үрийн төмснөөс эхлээд жилийн 5 сая төгрөгийн орлоготой ногоочин болсон эмэгтэйчүүд манай жижиг зээлийн сангаас эхний зээлээ авч, сургалтад хамрагдаж гараагаа эхэлсэн байдаг. Эмэгтэйчүүдэд зах зээлийн харилцааны үндсэн ойлголт өгөх, жижиг бизнесийн төлөвлөгөө хийх, нягтлан бодох анхан шатны бүртгэл хөтлөх, зээлийн эргэн төлөлтийн график тооцоо хийх, үр ашгаа тооцохоос эхлээд амьдрах ухааны төрөл бүрийн сургалт явуулж байлаа. Жижиг зээл нь Монгол улсын хувьд шинэлэг байсан тул уг төслийг хэрэгжүүлж ирсэн ажилтнуудын мэдлэг дадлагыг дээшлүүлэх үүднээс НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн төслийн санхүүжилтээр 1993 онд Филиппин улсад жижиг зээлийн үйл ажиллагаатай танилцан суралцах аялалыг зохион байгуулжээ. Энэ аялалд МЭХ-ны дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг, гадаад харилцааны ажилтан Б.Уранчимэг, Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга П.Алтанцэцэг нар оролцсон юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд эмэгтэйчүүдийн ядуурлыг бууруулж, жижиг үйлдвэрлэл эрхэлж байгаа туршлагыг судлуулахаар МЭХ-ны төв аппарат, Улаанбаатар хот, Төв, Дорноговь аймгийн ЭЗ-ийн төлөөлөгчдийг аялуулжээ. ТАСИС хөтөлбөрөөс МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг, холбооны ажилтан Б.Одончимэг, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган аймгийн ЭЗ-ийн дарга Н.Золзаяа, Ё.Цэцэгээ, Заяа, Оюунчимэг нарыг Итали улсын APS ТББ байгууллага дээр хүлээн авч 2 сарын дадлага, танилцах аялал зохион байгуулав. Үүний зэрэгцээ НҮБ-ын “Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан”, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, ТАСИС хөтөлбөрийн мэргэжилтэн, сайн дурын ажилтнууд Монголд ирж эмэгтэйчүүдэд жижиг зээл олгох, жижиг бизнес эрхлэх сургалт, семинар, уулзалтуудыг зохион байгуулж, МЭХ-ны гишүүн байгууллагуудын удирдлагууд идэвхтэн сонгуультнуудаас гадна сумдын Засаг дарга, ЭЗ-ийн дарга нарыг оролцуулан тэдний жижиг зээлийн мэдлэгийг дээшлүүлэх талаар ихээхэн ажил хийсэн байна. Олон улсын байгууллагуудын Монгол дахь төлөөлөгчид болох НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн ажилтан О.Оюунцэцэг, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн дарга С.Онон нарын зэрэг хүмүүс эмэгтэйчүүдэд зориулсан төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлж хамтран ажиллаж байжээ. Монголын Эмэгтэйчүүдийн Холбооноос хэрэгжүүлж байсан жижиг зээлийн төслүүд эргэн төлөлтийн хувь өндөр, амжилттай хэрэгжиж байсан учраас 1990-ээд оны дундуур Азийн хөгжлийн банкны зээл орж ирэхэд хамтран хэрэгжүүлэх 3 ТББ байгууллага сонгож авсаны нэг нь манай байгууллага байлаа. МЭХ зээл авах шаардлага хангасан эмэгтэйчүүдийг сонгож Банкинд тодорхойлох үүрэгтэй байсан хэдий ч энэ ажилыг банк үл ойшоож, манай материалын дагуу чухам хэнд нь зээл өгсөн, өгөөгүйгээ ч тооцож мэдээлэхгүй байсан бөгөөд улмаар энэ төслөөс томоохон зээл авсан дийлэнх хүмүүс зээлээ төлөөгүй гэдэг бөгөөд энэ тухай нийгэм даяар яригдаж, сонинд бичигдэж, энэ уур амьсгал манай жижиг зээлийн төслийн хэрэгжилтэнд сөрөг үр дагавар авчирсан юм. Томчууд хэдэн зуун саяын зээлээ төлөхгүй байхад бид яагаад, 50 000, 100 000 төгрөгийн зээлээ хүүтэй нь уцааж төлөх ёстой юм вэ гэж ядуу эмэгтэйчүүд дургүйцэж байлаа. Зээлийн эргэн төлөлтийн хувь 76, 48, улмаар 36 хувь болтлоо буурч, аймаг, хотын ЭЗ-ийн дарга нар баахан зээл төлөөгүй эмэгтэйчүүдийг шүүхэд шилжүүлэхдээ тулаад байв. Иймээс 2001-2002 онд МЭХ-ны Удирдах зөвлөлийн

шийдвэрээр бүх зээлийн эргэлтийн сангийн 50 хувийг “Орон нутгийн хөгжлийн сан” болгон аймаг, хотын ЭЗ-ийн мэдэлд шилжүүлж, үлдсэн 50 хувийг 3 жилийн хугацаанд татаж авсан билээ. Харин Азийн хөгжлийн банкны шугамаар Филиппин дэх Хоршоодын холбооны сургалтын төвд П Алтанцэцэг нэг сарын сургалтад хамрагдаж, Хадгаламж зээлийн хоршоо / ХЗХ / байгуулах сургалтыг Филиппиний мэргэжилтнүүд Улаанбаатарт ирж явуулсан бөгөөд эмэгтэйчүүдийн бүлгүүдийг хоршоо болгон хөгжүүлэх ажил эхэлсэн юм. МЭХ-ны дэргэд 1997 онд “Гүнж-Анх” ХЗХ байгуулагдаж улмаар 2000 онд Улаанбаатарт “Гүнж-Эх”, 2001 онд Өвөрхангайд “Гүнж-Мөнх”, Архангайд “Бас-Гүнж”, Увс аймаг “Есөн цэн”, Баян-Өлгийд “Асал-Болат”, Дорноговьд “Сод өмч”, 2002 онд Төв аймагт “Гүнж-Төв”, Орхон аймагт “Эрдэнэт Дагинас”, Хар хорин суманд “Гүнж-Хархорин” ХЗХ байгуулагдан амжилттай ажиллаж байлаа. Эдгээр хоршоодын зарим нь 2007 оныг хүртэл амжилттай ажилласан бөгөөд гол нь Монгол дахь ХЗХ-дын хямрал будилааны улмаас шалтгаалан, нөгөө талаар банк санхүүгийн тогтолцоо өргөжин тэлсний улмаас үүргээ гүйцэтгэсэн гэж үзээд үүсгэн байгуулагчид нь татан буулгасан байдаг.

Европын холбооны ТАСИС хөтөлбөрийн хүрээнд 90 –ээд оны дунд үед хөгжлийн 2 төсөл авч хэрэгжүүлсэн билээ. Нэг нь эмэгтэйчүүдийн бичил бизнесийг дэмжих, аялал жуулчлалын бизнесийн эхлүүлэх, нөгөө нь эмэгтэйчүүдийг хэвлэлийг сайжруулах төсөл байсан юм. Эхний төслийн хүрээнд холбооны бүх гишүүн байгууллагын дарга нарыг жендэр, хөгжлийн оролцооны асуудлаар сургаж, сонгож авсан 4 аймгийн бүх сумдын ЭЗ-ийн дарга нарыг Засаг дарга нарынх нь хамт жижиг зээлийн сургалтад хамруулан зээлийн сан байгуулж өгөв. Мөн аялал жуулчлал хөгжих бололцоотой 10 аймгаас тус бүр 1 хүнийг тусгай сургалтад хамруулан бизнесээ эхлэх тус бүр 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн билээ. Одоо эдгээрийн зарим нь ажилласаар байна. МЭХ-ны хэвлэл Монголжингоо сонин зах зээлийн ороо бусгаа үед тасалдалгүй гарч, эмэгтэйчүүдэд мэдээлэл хүргэхэд ТАСИС хөтөлбөрийн төсөл үнэлж баршгүй дэмжлэг болсон билээ. Гэвч зарим нэг атаач хүмүүс ТАСИС хөтөлбөрийн удирдлагыг коммунист байгууллагыг дэмжсэн хэмээн матаан гомдоож, манай төслийг Брюсселээс хүмүүс ирж шалгаж байсан билээ. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг улс төржүүлсэн, улс төрийн өнгө аясаар ялгаварлан цаанаа төслийн санхүүжилт авах далд санаа агуулсан арчаагүй этгээдүүд олон улсын байгууллагуудыг ашиглан эгэл жирийн олон мянган эмэгтэйчүүдэд хүрэх ёстой төсөл хөтөлбөрийг үр ашиггүй үрэн таран хийсэн юм. Төслийн санхүүжилт зогсохоор алга болчихдог, төсөл хөтөлбөр зарлахаар бий болчихдог ТББ-ууд байсаар байна. Олон улсын байгууллагын зарим ажилтнууд ч гэсэн тогтвортой ажиллагаатай, үндэсний байгууллагыг дэмжихийн оронд янз бүрийн ашиг сонирхолоор Монгол улсад зориулагдсан хөрөнгийг үрэн таран хийсээр байна.

НҮБ-ын Хүнс ХАА-г хөгжүүлэх олон улсын сангаас МУЗГ-тай хамтран хэрэгжүүлэх “Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр” / ХЯБХ /- ийн хамтран хэрэгжүүлэгч ТББ-аар МЭХ-г сонгож авсан юм. Олон улсын экспертүүд Монголд ирж олон байгууллагатай уулзаж, үйл ажиллагаатай нь танилцаад МЭХ-г сонгосон байхад манай УИХ дээр яагаад энэ байгууллага гэж хэмээн хэл яриа болж байсан гэдэг. 2003 онд бэлтгэл нь хангагдаж 2004 – 2010 онд хэрэгжих энэ төслийн “Эмэгтэйчүүдийн хөгжил” дэд хэсгийг манай байгууллага хариуцаж, Архангай, Булган, Хэнтий, Хөвсгөл гэсэн 4 аймгийн бүх сумдад эмэгтэйчүүдэд хүрч ажиллав. Гэр бүл төлөвлөлт, орлого бий болгох үйл ажиллагааны сургалт зохион байгуулж, аймаг, сумдын ЭЗ-ийн чадавхи бэхжсэн билээ. Энэ хөтөлбөрийн дагуу 120 сая төгрөгийн санхүүжилттэй “Эмэгтэйчүүдийн бичил санаачилгыг дэмжих сан” ажиллах ёстой байсан боловч Сангийн яам ТББ жижиг зээл олгох ёсгүй гэж үзэж 2007 оныг хүртэл уг санхүүжилтийг олгосонгүй. Сургалтад хамруулсан эмэгтэйчүүдийг дэмжиж, жижиг зээл олгоод орлогыг нь нэмэгдүүлэх бодитой ажил үгүйлэгдэж байлаа. Ийм учраас МЭХ-ноос уг санхүүжилтийг ХАС Банкинд байршуулж, банкаар дамжуулан жижиг зээл олгоё гэдэг санаачилга гаргасан юм. Яам, Банк, Хөтөлбөрийг дэмжих нэгж, МЭХ-ны хооронд гэрээ байгуулагдаж, сангийн дүрмийг боловсруулж, “Эмэгтэйчүүдийн бичил санаачилгыг дэмжих сан”-гаас ядуу эмэгтэйчүүдэд барьцаагүй зээл олгож эхэлснээс хойшхи нэг жилийн хугацаанд 4 аймгийн 26 суманд эмэгтэйчүүдийн 203 бүлэгт 78.7 сая төгрөгийн, 95 эмэгтэйд 60 сая төгрөгийн ганцаарчилсан зээл олгосон байна. Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулж, барьцаагүй зээл олгон эргэн төлөлтийг сар

тутамд графикаар хийлгэснээр эцсийн дүндээ зээлдэгчид ашигтай, маш бага хүүгийн ашиг тооцдог, гол нь эргэлт сайтай, олон хүнийг хамардаг хөгжлийн зээлийн энэхүү хэлбэрийг МЭХ 90-ээд оны эхнээс НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн төслөөс эхлэн хэрэгжүүлсэн билээ. Гэвч бидний энэ туршлагыг төр засаг бас л тоож ойшоогоогүй юм. Бүлэг байгуулах, бүлгийн зээл олгох сургагчаар олон улсын АДРА байгууллагыг сонгон авч, одоо бид АДРА-гийн технологээр ажиллаж, сургалт зохион байгуулах болбол өндөр үнээр сургалтыг худалдан авч байна. Энэхүү бүлгийн зээлийн ажиллагаанд ХАС Банк, олон улсын судалгааны байгууллагатай хамтран үр дүнгийн судалгаа хийж байгаа бөгөөд орон нутгийн ядуу иргэдэд жижиг зээл ихээхэн хэрэгтэй, аж амьдралаа дээшлүүлэхэд нь тустай болох нь эртнээс харагдаж байна. Ийм учраас ХЯБХ-ийн шугамаар дахин 800 000 америк долларын жижиг зээлийн санхүүжилт гаргаж ХААН Банкинд байршуулан МЭХ-ны орон нутаг дахь гишүүн байгууллагуудтай хамтран дээрх 4 аймгийн бүх сумдад бүлгийн зээл олгохоор шийдвэрлээд байна. Эдгээр арга ажиллагааны үр дүнд Монгол улсад шинээр бүрэлдсэн банк - санхүүгийн байгууллагын шинэ үеийн харилцагчдыг бэлтгэсэн билээ.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн төслийг хэрэгжүүлсэн нь:

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр 1994-1998 онд “Эсэн мэнд амаржихуй” нэртэй цуврал сургалтыг Эрүүл мэндийн яамны мэргэжлийн хүмүүстэй хамтран зохион байгуулж, эмэгтэйчүүдэд хүүхэд төрүүлэх асуудлаа өөрийн эрүүл мэндийн байдалд зохицуулан шийдвэрлэх мэдлэг олгож гэр бүлийн гишүүд өөрсдийн эрүүл мэнд, хөрөнгө чинээ, хүүхэд өсгөх нөхцөл бололцоогоо харилцан ярилцаж төлөвлөн хэрэгжүүлэхийн ач холбогдлыг таниулж байв. Энэ үеэс “гэр бүл төлөвлөлт” гэдэг ухагдахууныг нийгэмд шинээр гаргаж тавьсан бөгөөд зарим эрдэмтэд, иргэд өрөөсгөлөөр ойлгож эсэргүүцэж байв. Эмэгтэй хүн эх болох эрхээ өөрөө шийдвэрлэхдээ аборт хийлгэж, эрүүл мэндээ хохироох замаар бус гэр бүлийн гишүүдтэйгээ зөвлөж, эрүүл мэндийн хувьд боломжтой үедээ жирэмслэх тухай сургалтын агуулгыг нийгмийн зарим хэсэг буруугаар ойлгож байсан юм. Энэ төсөл улмаар эх нялхасын эрүүл мэндийг хамгаалах нь нийгэм, гэр бүл, эрэгтэй, эмэгтэй иргэн бүрийн оролцоо, хүний эрхийн бүхий л талыг хамарсан өргөн ойлголт болохыг нийгэмд тавьж, улам бүр өргөжин аймаг бүрт сургалт явуулж, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн тухай ойлголтыг Монгол улсын нийт иргэдэд ойлгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байна. НҮБ-ын Хүн амын сан, Ази номхон далайн орнуудын эмэгтэйчүүдийн хөгжлийн төвүүдээс гадаад, дотоодод нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар зохион байгуулсан олон хурал семинарт МЭХ-ны удирдлагуудыг оролцуулж, холбооны ажилтнуудаас гадна бүх аймаг, хотын ЭЗ-ийн дарга нарыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургагч багш болгон бэлтгэж, оюуны томоохон хөрөнгө оруулалт хийсэн билээ. Энэ ажлыг МЭХ-ны ажилтан Б Одончимэг хариуцаж байжээ.

Нийгмийн харилцааны шинэчлэлтийн үед зарим сөрөг үр дагавар гарч, эмэгтэйчүүд ил тодоор биеэ үнэлэх болов. Тэднийг бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлж, эрүүл мэндийг нь хамгаалах, улмаар амьдралын арга ухаанд сургаж, биеэ үнэлэх замаас татан гаргах явдал чухал байлаа. Ард кино театрыг сонгон авч тэнд биеэ үнэлдэг хүүхнүүдтэй ажиллах төсөл боловсруулж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас дэмжлэг, санхүүжилт авсан юм. Тэдгээр эмэгтэйчүүдтэй уулзаж, амьдралын нарийн ширийн зовлонг сонсохын ялдамд эрүүл мэндээ хамгаалах арга замыг нь заан өгч, гондом тарааж байв. Улмаар өөрөөр амьдрах арга зам заах “Амьдрах ухааны сургалт”-д хамруулан бага насны хүүхэдтэй эхчүүдэд мөнгөн дэмжлэг үзүүлж байжээ. Энэ ажлыг МЭХ-ны ажилтан Олончимэг хариуцаж байв.

ДОХ, сүрьеэгээс эмэгтэйчүүд, эхчүүдийг сэргийлэх асуудал чухлаар тавигдсан юм. МЭХ өөрийн Монголжингоо сониноор дамжуулан алсын зайны сургалт явуулах төслийг боловсруулж, 2003 – 2004 онд олон улсын Глобаль Санд хандан дэмжлэг авсан юм. Эдгээр нийгмийн халдварт өвчний тухай мэргэжлийн байгууллагаас гаргасан материалыг энгийн эмэгтэйчүүдэд ойлгомжтой хэлбэрээр хялбаршуулан цуврал хичээл бэлтгэж Монголжингоо сонинд хэвлээд, 9 аймаг, 2 дүүргийн тус бүр 100 ядуу өрхийн эмэгтэйчүүдэд сониноо ЭЗ-өөр дамжуулан үнэгүй

тарааж, дараа нь нэг өдрийн ойрын зайн сургалтад тэдгээр эмэгтэйчүүдийг хамруулан харилцан ярилцах хэлбэрээр ойлголтыг нь бататгаж байлаа. Сургалт бүү хэл, өөр ямар ч олон нийтийн арга хэмжээнд орж байгаагүй эмзэг бүлгийн эмэгтэйчүүд энэ сургалтад оролцохын тулд хүүхдээ хамт хөтлөн ирж, их зүйл мэдэж ойлгосноо талархан хэлж байсан юм. Зарим эрэгтэйчүүд эхнэрээ сургалтад оруулаад сургалтын байрны үүдэн дээр хүүхдээ харж байлаа. Эмэгтэйчүүдэд сургалтын явцад хоол, цайгаар үйлчилж, сонин уншаад юу ойлгосон, амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж байгааг нь чөлөөтэй яриулж байлаа. Энэ нь амьдралын гачигдалтай эхчүүдийг нийгэмшүүлэх, ярих, олон нийттэй харьцах дадлага олгох давхар ач холбогдолтой ажил болсон юм. Энэ ажлыг МЭХ-ны Монголжингоо сонины ажилтан Ш Ариунаа хариуцаж байв.

МУЗГ, Азийн хөгжлийн банкнаас “Ядуу эх хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах хөтөлбөр” хэрэгжүүлэхэд эхчүүдийн сургалт-сурталчилгааны ажлыг МЭХ хариуцсан юм. Иоджуулсан давс, төмрөөр баяжуулсан гурилыг хэрэглэхийн ач холбогдлыг сурталчилсан юм. Хүний эрүүл мэнд, ялангуяа хүүхдэд иод, төмөр дутагдахад ямар эмгэг үүсдэг тухай хялбаршуулсан сургалтын гарын авлага боловсруулж, хөтөлбөрт хамрагдсан аймаг, сумдын ядуу эмэгтэйчүүдэд хүргэсэн билээ. Орон нутагт бүсчилсэн семинар хийж, сургагч багш нарыг бэлтгэн тэднээр гарын авлага тараалгаж байв. Сургалт-семинарт ядуу эмэгтэйчүүдийн төлөөлөгчдийг оруулж, баяжуулсан гурил, иоджуулсан давс үнэгүй өгч байв. МЭХ-ны ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэг хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны гишүүний хувьд Казакстан улсын Алма-ата хотноо болсон Азийн хөгжлийн банкны зөвлөлдөх уулзалтад улсаа төлөөлөн үг хэлж, санал гаргаж байжээ.

Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш эрхийг хангахад чиглэгдсэн төслүүд:

Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш эрхийг хангах асуудал 1990 оноос хойш МЭХ-ны Удирдах зөвлөлийн анхааралд байнга байж, үйл ажиллагааны үндсэн чиглэл болж ирсэн юм. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангаас Жендэрийн асуудлаар Бээжин хотноо 1991 онд сургалт зохион байгуулахад МЭХ-ноос тэр үед УБ хотын ЭЗ-ийн дарга байсан Ж Эрдэнэчимэг, Гадаад яамны ажилтан О. Энхцэцэг нарыг явуулжээ. Энэ үед Эмэгтэйчүүдийн асуудлаарх Үндэсний механизмыг боловсронгуй болгох тухай асуудал яригдаж, бүтэц тогтолцооны оновчтой хувилбарыг эрж хайж байлаа. МЭХ төр засгийн тогтолцооноос гарч ТББ болон өөрийн замаар хөгжиж, харин төр засагт эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан нэгж байхгүй байв. Нэг хэсэг Эрүүл мэндийн яамны хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийн газарт харьяалагдаж байсан энэ асуудлыг Хүн амын бодлого хөдөлмөрийн яаманд шилжүүлэн Эмэгтэйчүүдийн тасаг байгуулахад хотын ЭЗ-ийн дарга Ж Эрдэнэчимэгийг Яаманд татан авсан бөгөөд тэрээр энд ажиллах хугацаандаа Японы Жайка байгууллагын шугамаар Токио хотноо “эмэгтэйчүүдийн асуудлаарх Үндэсний механизм” сэдэвт сургалтад хамрагдаж, “Өүлэн ээж” хөтөлбөрийг боловсруулан Яамны Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлж байсан нь МУЗГ-ын “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөр”-ийн угтал болжээ. Энэхүү Эмэгтэйчүүдийн тасгаас Монгол улсын Гэр бүлийн хуулийг шинэчлэн боловсруулах ажилд оролцож, Ази номхон далайн бүсийн Олон улсын гэр бүлийн жилийн бэлтгэл хуралд оролцож, гэр бүлийн хуулийн асуудлаар илтгэл тавьсан байдаг.

МЭХ-ноос эмэгтэйчүүдийн эрх, шийдвэр гаргах шатны оролцоо, жендэрийн тэгш эрхийн асуудлаар олон тооны цуврал сургалтуудыг төв, орон нутагт явуулж, “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөр”, “Жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөр”-үүдийг боловсруулахад идэвхитэй ажиллаж байв. Улмаар МУЗГ-аас Үндэсний зөвшилцөх уулзалтаар хэлэлцүүлж, “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг батлахад хөтөлбөрийг өргөн олонд таниулан сурталчлах ажлыг МЭХ, НХХЯамтай хамтран зохион байгуулсан байна. Яамны санхүүжилтээр бүсчилсэн семинар зохион байгуулж, хөтөлбөрийг хялбаршуулан танилцуулсан брошюр хэвлүүлэн тарааж, Монголжингоо сониноор дамжуулан хэлэлцүүлэг явуулж байжээ.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн “Үр дүнгийн төлөө манлайлал” хөтөлбөрт МЭХ 2005 оноос хамрагдсан юм. Холбооны ерөнхийлөгч Ж. Эрдэнэчимэг удирдах ажилтны 3 үе шаттай сургалтад хамрагдаж улмаар сургагч багш бэлтгэх 2 үе шаттай сургалтад Энэтхэг улсад явж суралцсан юм. Дараа нь “Эмэгтэйчүүдийн маналайлал: Брэнд бүтээгдэхүүн” төслийг санаачилж, боловсруулан хэрэгжүүлжээ. Төсөлд гишүүн холбооны идэвхитэн сонгуультнуудаас гадна гар урлал, жижиг бизнес эрхэлдэг эмэгтэйчүүд хамрагдаж, бүтээгдэхүүнийхээ өнгө, дизайныг сайжруулснаас гадна маркетингийн сургалтад хамрагдаж, үзэсгэлэн – худалдаа зохион байгуулсан байна. Төслийн үр дүнд 60 орчим гар урлалчдаас 10 эмэгтэйг шалгаруулан бүтээгдэхүүний танилцуулга хэвлэж тараажээ. “Үр дүнгийн төлөө манлайлал” хөтөлбөрийн эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагаа нь МЭХ-ны төв, орон нутаг дахь олон мянган идэвхитэн дэмжигчдийн нийгмийн идэвх, урмыг сэргээсэн жинхэнэ оюуны хөрөнгө оруулалт болсон юм.

МУЗГ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс Швед, Японы Засгийн газрын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр “Жендэрийн мэдрэмжтэй төсвийн санаачилга” нэртэй төслийг 2003 – 2004 онд хэрэгжүүлсэн юм. Төслийн Үндэсний зөвлөхийн сонгон шалгаруулалтад МЭХ-ны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг шалгарч ажиллав. Санхүү эдийн засгийн Сайдын тушаалаар Жендэрийн мэдрэмжтэй төсвийн хүрээг тодорхойлох, шинжилгээ судалгааны дүнг бодлого хөтөлбөрүүдэд тусгах, судалгаа, төслийн явцад хяналт тавих, төслийг үр дүнтэй амжилттай хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахад ажлын хэсгийн дарга бөгөөд төслийн удирдагчаар Сангийн яамны хэлтсийн дарга Энхбаяр, гишүүдэд УИХ-ын гишүүн Н.Болормаа, Н.Гэрэлсүрэн, Б.Эрдэнэбилэгт, НХХЯ-ны ажилтан Рэгзэн, НҮБ-ын ХХГ-ын ажилтан Сарантуяа нар ажиллав. Төслийн хүрээнд төр засгийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөд сургалт явуулж, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалалын салбарт зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө, эдгээр салбарт зарцуулж байгаа хандивлагчдын зээл тусламжийн хөрөнгөнд жендэрийн болон ядуурлын дүн шинжилгээ хийх судалгааны ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсэн байдаг. Мөн жендэрийн мэдрэмжтэй төсөл боловсруулах чадавхийг орон нутагт бэхжүүлэх зорилгоор бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулсан байна. Жендэрийн мэдрэмжтэй төсөв нь Монголын хувьд урьд өмнө яригдаж байгаагүй шинэлэг зүйл байв. Энэ утгаараа МЭХ-ны төв, орон нутгийн сонгуульт ажилтны мэдлэгийг өргөжүүлж, чадавхийг бэхжүүлэхэд чухал алхам болсон юм.

Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн төслүүд:

МЭХ-ны Удирдах зөвлөл зах зээлийн шинэ харилцааны ороо бусгаа эхэн үед хүүхдийн эрх ашгийг хамгаалахын үндэс нь эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дээшлүүлэхэд оршиж байгааг олж харсан юм. Тийм учраас 1998-1999 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсрол” сэдэвт төсөл хэрэгжүүлсэн юм. Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн талаас УБИС-ийн эрдэмтэн багш нар, тухайлбал, багш Мягмар, Даваа, Монголын хүүхдийн үндэсний төвийн ахлах ажилтан Төвшинтөгс, НҮБ-ын Хүүхдийн сангийн ажилтан Б.Уранчимэг нар чин сэтгэлийн туслалцаа үзүүлж байсан ба төслийн санхүүжилтээр эцэг эхэд зориулсан “Хүүхэд насны хонх” нэртэй цуврал нэвтрүүлэг явуулж, эцэг эхэд зөвлөгөө өгөх, хүүхдийн дунд “Манай гэр бүл” сэдэвт гар зургийн уралдаан зарлаж зургаар илэрхийлсэн хүүхдийн бодол санааг эцэг эхэд үзүүлж ярилцлага зохион байгуулах хэлбэрээр ажиллаж байв.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад чиглэгдсэн “Налайх дүүрэг дэх нүүрсний уурхайд ажиллаж байгаа хүүхдийн судалгаа” төслийг боловсруулан өөрийн гишүүн байгууллага болох Улаанбаатар хотын ЭЗ, Налайх дүүргийн ЭЗ-өөр дамжуулан хэрэгжүүлсэн байдаг. Энэ төслөөр уурхайд ажиллаж байгаа хүүхдийн эрүүл мэндийн байдал, суралцах нөхцөл бололцоо, тэдгээр хүүхдийн гэр бүлд үзүүлэх тусламжийн асуудлаар судалгаа хийн дүгнэлт гаргаж, хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан эрүүлжүүлэх арга хэмжээ авсны зэрэгцээ хүүхдүүдийг уурхайн хүнд хөдөлмөрөөс чөлөөлж, суралцах нөхцлөөр хангах арга хэмжээг авсан тул хоёр дахь шатны төслийг авч хэрэгжүүлсэн юм. Энэ төслийн хүрээнд Монгол улсад анх удаа

“Хүүхдийг тэвчишгүй, хүнд хөдөлмөрөөс сэргийлье” гэсэн агуулга бүхий ашгийн бус сурталчилгааны том самбарыг Налайх дүүрэгт байршуулсан байдаг.

Хөдөөгийн эмэгтэйчүүдийн боловсролыг дээшлүүлэх төслүүд:

НҮБ-ын Боловсрол, Соёл, ШУ-ны байгууллагын дэмжлэгээр, Монгол улсын анхны Ерөнхийлөгч П Очирбатын ивээл дор 1996-1998 онд Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгийн говийн сумдад “Говийн малчин эмэгтэйчүүдийн албан бус боловсрол”-ын төсөл хэрэгжихэд хамтран ажиллагч ТББ-аар МЭХ, түүний орон нутаг дахь гишүүн байгууллагууд сонгогдсон юм. Энэ төслөөр говийн малчин эмэгтэйчүүдэд зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих арга зам, эрүүл мэндийн болон бичиг үсгийн боловсролоо дээшлүүлэх, амьдрах ухааны буюу малын гаралтай түүхий эдийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Тб, гэрийн нөхцөлд ноос, ноолуур боловсруулж гар урлал хийх сургалтуудыг явуулсан юм. Сургалтын хэлбэр нь тухайн үедээ Монгол улсад шинэлэг алсын зайны сургалт байлаа. Монголын радио, телевизээр сургалтыг явуулж, малчин өрхүүдэд радио хүлээн авагч болон түүний зай батареийг тараан өгч байв. Бас олон тооны гарын авлагыг хэвлэн тарааж, явуулын багш нар малчин өрхөөр орж эмэгтэйчүүдийн сурсан хийсэн зүйлтэй танилцан зөвлөгөө өгч байв. Аймаг бүрт иж бүрэн төхөөрөмжлөгдсөн Сургалтын төвүүд байгуулагдсан нь олон арван эмэгтэйчүүд, иргэдийг өөрийнхөө нөөц бололцоог ашиглан амьдрал ахуйгаа дээшлүүлэх арга ухаанд сургасан ба алсын зайны сургалтын арга зүйг амьдралд бодитойгоор туршиж улмаар бие даасан алба үүсч хөгжих нөхцлийг бүрдүүлсэн юм. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд МЭХ-нд хөдөө ажлын УАЗ 469 автомашин өгсөн боловч төсөл дууссаны дараа Ардын боловсролын яам хурааж авсан билээ.

Хөдөөгийн эмэгтэйчүүдэд зориулсан төсөл зөвхөн үүгээр хязгаарлагдаагүй. Ер нь МЭХ-ноос хэрэгжүүлсэн бараг бүх төслүүд орон нутагт, тэр дундаа аймаг, сумдын эмэгтэйчүүдэд чиглэгдэж ирсэн юм. Хөдөөгийн малчин, тариаланч эмэгтэйчүүдэд хүрч ажиллахын тулд МЭХ Монголын радиотой гэрээ байгуулж, эмэгтэйчүүдэд зориулсан нэвтрүүлэг явуулдаг туршлага одоо ч үргэлжилсээр байна. Гэвч гол нь санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан тогтмол бус байдаг болжээ. МЭХ-ны Монголжингоо сонин бол орон нутагт хэвлэл мэдээллийн хэрэгслээс хол хөндий байгаа эмэгтэйчүүдэд мэдээлэл хүргэдэг гол арга зам юм.

Монголын эмэгтэйчүүдийн нийгмийн байдлыг судалсан нь:

МЭХ-ноос аливаа төслийг хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүдийн нийгмийн байдалд дүн шинжилгээ хийж, гарсан дүгнэлтэнд тулгуурлан төсөл хөтөлбөр боловсруулж, хандивлагч байгууллагуудад хандан дэмжлэг авч ажиллаж ирсэн юм. Дүн шинжилгээг хийхдээ Үндэсний статистиктийн газраас болон салбарын яамд, тусгай газраас гаргасан албан ёсны статистик тоо баримтыг ашиглахаас гадна өөрийн гишүүн байгууллагын идэвхитэн сонгуультнаар дамжуулан мэдээ баримт цуглуулж ашиглаж ирсэн болно. Тухайлбал, Хөдөөгийн Ядуурлыг Бууруулах Хөтөлбөрийн хүрээнд сумдад байх ёстой хүнд чиглэсэн үйлчилгээг урьдчилан хэлэлцэж гаргаад, түүнээс хэд нь орон нутагт байгааг судлан дүгнэлт хийж, эмэгтэйчүүдийн жижиг бизнесийг хөгжүүлэх санааг гаргаж байв. Мөн түүнчлэн тусгайлан судалгааны төслүүдийг хэрэгжүүлж байв. Эдгээрийг дурдвал,

- 1998 он. Монголын Бизнес хөгжлийн Агентлагтай хамтран бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдийн дунд судалгаа. / Улаанбаатар хотын бүх дүүрэгт /
- 1999 он. Дэлхийн Банкны төслийн хүрээнд Гэр хорооллын өрхийн хэрэглэж буй ердийн зуухны хэмжээг тодруулах судалгаа. / УБ хотын 6 дүүргийн 12 хорооны 256 өрхөд /
- 1999 он. Дэлхийн Банкны төслийн хүрээнд Г-2 зуухны гүйцэтгэлд буюу 1997 Оноос тавигдсан зуухны нүүрс зарцуулалтад хийсэн судалгаа / СБ дүүргийн 9 дүгээр хорооны 50 өрхөд /
- 1999 он Дэлхийн Банкны төслийн хүрээнд гэр хорооллын эрчим хүчний Судалгаа / 6 дүүргийн 12 хорооны 451 өрхөд /

2000 он	Налайхын уурхайд албан бус хөдөлмөр эрхэлж буй насанд хүрээгүй хүүхдүүдийн судалгаа
2000 он	Сайжруулсан зуухны өмнөх ба дараах түлш зарцуулалтыг харьцуулан судлах хэмжилт хийх судалгаа / Сонгосон 40 өрхөд /
2003 он	Хувийн хэвшилд бизнес эрхлэгчдийн жендэрийн судалгаа / УБ хот, 11 аймаг /
2008-2009	Бүлгийн болон ганцаарчилсан бичил зээлийн үр дүнгийн судалгаа
2009 он	Хүнсний болон Байгал орчны аюулгүй байдалд эмэгтэйчүүдийн иргэний нийгмийн зүгээс хийх хяналт-үнэлгээний асуулга судалгаа

МЭХ-ны ажилтан, идэвхитэн сонгуультнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлсэн нь:

МЭХ өөрийн ажилтан, сонгуульт идэвхитэнгүүдийг гадаад, дотоодын сургалт-семинарт хамруулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ирсэний дүнд олон ажилтан өсөн хөгжиж, сонгуульт ажилдаа тогтвор суурьшилтай ажиллахын зэрэгцээ зарим нь бизнесийн болон олон улсын байгууллагад ажиллах болсон билээ. МЭХ-ны гадаад харилцаа хариуцсан ажилтан Б Уранчимэг/НҮБХАС/, Мөнхжаргал/НҮБХХ/, Төгсбаяр /АХБ/, Олончимэг/Save the Children/ нар шалгаруулалтад тэнцэн олон улсын байгууллагад ажиллах болж, Н Золзаяа сэтгүүл зүйн чиглэлээр хувийн бизнес эрхэлж, Д Байгалмаа, С Хандмаа нар гадаадад сургууль, курст явж, Б Одончимэг УИХ-ын гишүүний биет төлөөлөгч болж, одоо ХЗХ ба ТББ-ын ажилтнаар ажиллаж байна. 90 оноос хойш анх НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангаас Жендэрийн асуудлаар Бээжин хотноо 1991 онд сургалт зохион байгуулахад МЭХ-ноос тэр үед УБ хотын ЭЗ-ийн дарга байсан Ж Эрдэнэчимэгийг явуулж, шинэ үзэл баримтлалын талаар мэдлэг олгосон байдаг. Түүнээс хойш бүх аймаг, хотын ЭЗ-ийн дарга нар жендэрийн ямар нэг шатны сургалтад хамрагдсанаас гадна бүгд “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургагч багш” болон бэлтгэгдэн сертификат авсан билээ. 1993 онд МЭХ-ны дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг, гадаад харилцааны ажилтан Б.Уранчимэг, Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга П Алтанцэцэг нар Филиппин улсад НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангаас зохион байгуулсан эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрхийг хамгаалах, ядуу эмэгтэйчүүдэд жижиг зээл олгох сургалтад хамрагдсан нь бичил зээлийн төсөл бичиж, санхүүжилт, дэмжлэг авч олон мянган эмэгтэйчүүдэд сургалт явуулахын зэрэгцээ зээл олгож орлогыг нь нэмэгдүүлэхэд нөлөөлсөн юм. ТАСИС хөтөлбөрийн шугамаар МЭХ-ны дэд ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэг, холбооны ажилтан Б Одончимэг, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган аймгийн ЭЗ-ийн дарга Н Золзаяа, Ё.Цэцэгээ, Заяа, Оюунчимэг нарыг Итали улсын APS ТББ байгууллага дээр түшиглэн эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн асуудал, жижиг зээл ба эмэгтэйчүүдийн хэвлэлийн асуудлаар 2 сарын сургалт, танилцах хийлгэв. БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах оронд эмэгтэйчүүдийн ядуурлыг бууруулж, жижиг үйлдвэрлэл эрхэлж байгаа туршлагыг судлуулахаар МЭХ-ны төв аппаратаас Б Уранчимэг, Улаанбаатар хотын ЭЗ-ийн дарга П Алтанцэцэг, Дорноговь аймгийн ЭЗ-ийн дарга П Долгорсүрэн нарыг илгээв. Азийн хөгжлийн банкны шугамаар Филиппин дэх Хоршоодын холбооны сургалтын төвд УБ хотын ЭЗ-ийн дарга П Алтанцэцэг нэг сарын сургалтад хамрагдаж, Филиппиний мэргэжилтнүүдийн УБ хотноо зохион байгуулсан Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/ байгуулах сургалтад бүх аймаг, хотын ЭЗ-ийн дарга нар хамрагдаж, дараа нь эмэгтэйчүүдийн бүлгүүдийг хоршоо болгон хөгжүүлэх ажил эхэлснээр 10 ХЗХ байгуулагдаж, 200 шахам эмэгтэйчүүд хөрөнгө хүчээ нэгтгэн ажилласнаар аж амьдралаа дээшлүүлсэн байдаг. Хөдөөгийн Ядуурлыг Бууруулах Хөтөлбөрийн шугамаар Булган, Хөвсгөл, Хэнтий аймгийн ЭЗ-ийн дарга Оюун, Л Баасанхүү, Валясүрэн, МЭХ-ны ажилтан Т Гүндэгмаа нар Энэтхэг улсад ядуучуудад бичил зээл олгож буй ажлын туршлагатай танилцжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд АДРА олон улсын байгууллагын “Өөртөө туслах бүлэг” байгуулах 2 үе шаттай сургалтад 4 аймаг, 80 сумын ЭЗ-ийн дарга нар, МЭХ-ноос явуулсан “Бүлгийн зээлийн сургалт”-д 4 аймгийн 70 гаруй сумын ЭЗ-ийн дарга нараас гадна 100 гаруй сонгуульт идэвхитэнгүүд хамрагдсан байна. Бангладеш улсад болсон ядууруулыг бууруулах сургалтад МЭХ-ны ажилтан Б.Батаа, Олончимэг нар, Кампучи улсад болсон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн сургалтад ажилтан Б Одончимэг нар хамрагдсан байдаг. Мөн Улаанбаатар

хотод нийт аппаратын ажилтнуудад зориулан монгол бичиг, англи хэлний сургалт зохион байгуулж байжээ. Холбооны Монголжингоо сонины эрхлэгч Ж Эрдэнэчимэг, ажилтан Ш Ариунаа, Г Ганчимэг нар Монголын хэвлэлийн хүрээлэнгээс зохион байгуулсан удаа дараагийн сургалтад сууж, хэвлэлийн болон сэтгүүл зүйн мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн юм. Сонгуульт идэвхитэний мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг төрөл бүрийн хэлбэрээр, орон нутагт зохион байгуулж байсны нэг жишээ нь Төв аймгийн Бүрэн суманд ЭМЯ-тай хамтран нөхөн үржихүйн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан явдал юм.

Шинэ нөхцөлд эмэгтэйчүүдийг удирдах, шийдвэр гаргах шатны ажиллагаанд оролцуулах явдал улам бүр хумигдаж, урд нь олсон ололтоос ухрах хандлага ажиглагдаж байлаа. 1998 онд Шведийн хөгжлийн байгууллагаас жил тутам зохион байгуулдаг “Удирдлага дахь эмэгтэйчүүд” сэдэвт сургалтад холбооны ерөнхийлөгч Ж. Эрдэнэчимэг Швед улсад явж оролцоод, дараа нь шийдвэр гаргах шатан дахь жендэрийн тэгш эрхийн асуудлаар Шведийн мэргэжилтнүүдтэй хамтран хэрэгжүүлэх томоохон төсөл авсан байдаг. Гэвч тэр үеийн МУЗГХЭГазрын дарга Шведийн мэргэжилтнүүдэд төслөө авья, өөр байгууллагаар хэрэгжүүлүүлье гэсний улмаас хэрэгжүүлж чадаагүй байна. Иргэний нийгмийн хөгжил дэх оролцооны дэвшилтэт хэлбэр, чиг хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг тусгаж, ажилтан идэвхитэнээ бэлтгэх явдал шаардагдаж байв. Монголын Нээлттэй нийгмийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Иргэний нийгмийн хяналт-үнэлгээ буюу мониторингийн 2 үе шаттай сургалтад МЭХ-ны УЗ-ийн гишүүн Ж Эрдэнэчимэг, ж маралмаа, ажилтан Ж Билэгдэмбэрэл, Т Гүндэгмаа, Г Ганчимэг, Н Цогзолмаа нарын 6 хүнийг сургаж, дараа нь “Тусгай зөвшөөрлийн олголтод иргэний нийгмийн хяналт-үнэлгээ хийсэн юм.

МЭХ өөрийн орон нутаг дахь гол түшиг тулгуур болсон сонгуульт идэвхитэнгүүдийн идэвх санаачилгыг өрнүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор 1996 оноос Зуны тойрон аялал зохион байгуулж, улмаар 2002 оноос Зуны сургалт – Тойрон аялал болгон өргөжүүлсэн юм.

МЭХ-ны идэвхитэн сонгуультны Зуны сургалт – Тойрон аялалууд:

- 1996 Хөвсгөл аймаг - Хөвсгөл далай тойрон аялал
- 1997 Хэнтий аймаг- Гурван нуур-Цагаан чулуут тойрон аялал
- 1998 Архангай аймаг- Хорго-Тэрхийн цагаан нуур тойрон аялал
- 1999 Хэнтий аймаг-Дадал-Гурван нуур тойрон аялал
- 2001 Өвөрхангай аймаг-Найман нуур тойрон аялал
- 2002 Баянхонгор аймаг-Өвгөн жаргалант-Шаргалзуут “Төмөр дутлын цус багадалт, иод дутлын эмгэгээс сэргийлэх нь” сургалт-тойрон аялал
- 2003 Баян-Өлгий аймаг-Зост-Сагсай-Алтай таван богд “Жендэрийн мэдрэмжтэй төсөв:Хяналт-үнэлгээний аргачлал” сургалт-тойрон аялал
- 2005 Хөвсгөл аймаг-Уран дөш-Хөвсгөл далай “Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг”, “Авилгалын эсрэг хөдөлгөөн” сургалт-тойрон аялал
- 2006 Хэнтий аймаг-Эзэн Чингисийн түүхэн дурсгалт газраар “Эмэгтэйчүүдийн Манлайлал: Брэнд бүтээгдэхүүн” сургалт-тойрон аялал
- 2007 Булган аймаг-Жаргалант-Уран тогоо “Төрийн бус байгууллагын менежмент” сургалт-тойрон аялал
- 2008 Архангай-Тамир-Тайхар-Тэрхийн цагаан нуур “Хүнсний аюулгүй байдал, Эмэгтэйчүүдийн бүлэг байгуулах нь” сургалт-тойрон аялал
- 2009 Дорнод, Сүхбаатар аймаг-Мэнэнгийн тал-Буйр нуур- Халх гол-Шилийн богд-Алтан овоо “Өөртөө туслах бүлэг: Бүлгийн зээлийн журам” сургалт-тойрон аялал

Эмэгтэйчүүдийн Сургалт- үйлдвэрлэлийн төвийг хөгжлийн төв болгон байгуулсан нь:

Монголын эмэгтэйчүүдийн хорооноос 1980-аад онд байгуулсан Соёлжих танхимууд зах зээлийн ороо бусгаа үед орон байргүй болж, санхүүжих арга барилаа ололгүй хаагдсаар зөвхөн холбооны дэргэдэх Сургалт-үйлдвэрлэлийн төв, Улаанбаатар хотын ЭЗ-ийн арга зүйн танхим, Орхон, Дархан-уул аймаг дахь эмэгтэйчүүдийн ордонгууд үлдэв. УБ хотын ЭЗ аргазүйн танхимынхаа байранд байрлах болж, Орхон, Дархан-Уул аймгийн ЭЗ-ийн дэргэдэх Эмэгтэйчүүдийн ордонгууд үйл ажиллагаагаа одоог хүртэл явуулсаар байна. Холбооны дэргэдэх Сургалт-үйлдвэрлэлийн төвийг 1990 -1996 онд холбооны гишүүн байгууллага болох

“Уран бүсгүй” нэгдэл /дарга нь Б Долгормаа/ хариуцан ажиллуулж байв. Төвийн захиралаар Б.Долгормаа, дараа нь Адъяа нар ажиллаж эмэгтэйчүүдэд оёдол, эсгүүрийн сургалт явуулж, захиалгаар үйлчилж байлаа. Багшаар нь Бямбаа ажиллаж байв. Тус төв өөрийн гэсэн байргүйн улмаас Соёлын төв өргөө, дараа нь Эрүүл мэндийн 7-р төвийн байранд түрээсээр байрлаж байлаа. МЭХ 1997 оноос Сургалт үйлдвэрлэлийн төвийг өөрийн дэргэд Тээврийн институтын байранд байрлуулж оёдол, эсгүүр, монгол бичгийн сургалтыг зохион байгуулав. Төвийн захирлаар С.Хандмаа, оёдол эсгүүрийн багшаар Бадамсүрэн, монгол бичгийн багшаар Самдан нар ажиллаж байв. МЭХ Авто тээврийн газрын байраас гарч, тээврийн институтэд түрээсээр орохдоо Сургалтын төвийг байртай болгох зорилгоор Улаанбаатар хотын Газрын албанаас газар хүсч Амгаланд газар авсан юм. Энэ үед Төв аймгийн ЭЗ-ийн дарга П Чулуунцэцэгийн гэр бүлийн хүн УБ хотын Газрын албаны орлогч даргаар ирсэн байв. Ж Эрдэнэчимэг, П Чулуунцэцэг нар газрын зөвшөөрөл авах бичиг баримтыг бүрдүүлж хүсэлтээ гаргахад тэр үеийн Газрын албаны дарга Даваабаатар өөрийн биеэр зөвлөж, МЭХ-г өөрийн гэсэн газартай, байртай байх ёстой байгууллага шүү хэмээн дэмжиж байсан билээ. Газраа авсны дараа НҮБХХ-ийн “Тогтвортой хөгжил:21 дүгээр зуун” хөтөлбөрийн газарт төсөл бичиж, сүрлээр Монгол улсад анхны 2 давхар байшин бариулах санхүүжилт олж авсан юм. Н Гэрэлсүрэн төслийн удирдлагуудаас зөвшөөрөл авч, Ж Эрдэнэчимэг төслийг боловсруулан бариулах ажлыг Чулуунцэцэгтэй хамтран зохион байгуулсан байдаг. НҮБХХ-өөс сүрлэн байшин барих ажлыг технологийн хувьд хариуцах байгууллагаар АДРА олон улсын байгууллагыг сонгосон ба МЭХ 6 аймгаас тус бүр 6 хүнийг сургалтад хамруулж, сүрлээр байшин барих дадлага эзэмшүүлсэн ба сүрлийг Төв аймагт бэлтгэж байв. Барилгын ашиглалтын өмнөх даамлаар болон ашиглалтад авсаны дараа Эмэгтйчүүдийн хөгжлийн төвийн захиралаар П Чулуунцэцэг ажиллаж байлаа. Солонго нийгэмлэгийн хандиваар байгуулсан зээлийн сангийн хөрөнгөнөөс уг төвд төмөр хашаа, гүний худаг, цахилгааны трансформатор барьж өгсөн юм. Энэ төвд хотын захын гэр хорооллын эхчүүд, хүүхдүүдэд зориулсан төрөл бүрийн сургалт, түүний дотор компьютер, англи хэл, оёдол нэхмэлийн болон сургуулиас завсардсан хүүхдэд бичиг үсэг заах сургалт явагдаж байв. Гэвч өвлийн улиралд халаалтын зардал өндөр, тог цахилгааны зардлыг гаргах хөрөнгийн эх үүсвэр дутагдаж байлаа. Амьдралын шаардлагаар Чулуунцэцэг өөр ажилд шилжихэд Мөнхцэцэг хариуцан ажиллаж байсан боловч сургалтыг үргэлжлүүлж чадалгүй компьютер зэрэг сургалтын техник тоног төхөөрөмжийг үрэн таран хийсэн юм. Иймээс түүнийг халж Цэрэнпагма сахиулаар ажиллаж байгаад МЭХ-ны ахмад ажилтан Ч Батчулууны өөрийнх нь хүсэлтээр сахиул хийлгэх болов. МЭХ-нд санхүүгийн боломж байхгүй байсан тул орлогоороо зарлагаа нөхөж ажиллуулах гэрээ байгуулсан байдаг. Ч Батчулуун гүний худгийн усыг борлуулж, олон улсын байгууллагын төслөөр засвар хийлгэж, нам даралтын зуух тавиулан халаалтын зардлыг багасгасан ба ахмадын “Шүр” хэмээх өдрийн амралт ажиллуулав. МЭХ-ны Хүндэт ерөнийлөгч Н Гэрэлсүрэн, УИХ-ын гишүүн байхдаа дээврийн засварт 500 000 төгрөг хандивлаж, МЭХЭЗ-ийн Ажлын алба тэнд байсан тоног төхөөрөмж, эд хогшилыг ашиглуулахаас гадна жижиг хэрэгсэл авч өгөх, боломжтой үедээ сар тутам бага зэргийн мөнгөн урамшуулал өгөх зэргээр төрөл бүрийн дэмжлэг үзүүлж байв. Гэвч газар эзэмшлийн болон үл хөдлөх хөрөнгийн татварыг МЭХ төлж, ямарч орлогогүй хирнээ зардал ихтэй ажиллаж байлаа. Иймээс МЭХ-ны Удирдах зөвлөлийн шийдвэрээр 2008 онд сүрлэн байрыг холбогдох эд хөрөнгийн хамт худалдаж, МЭХ-ны Ерөнхий зөвлөлийн Ажлын албанд хотын төвд шинэ байр худалдан авахад нэмэрлэсэн байна. Харин өөрийн төв байрандаа Ерөнхий зөвлөлийн хурлаа хийх бололцоотой болсон ба ХЯБХ-ийн сургалтууд, С.Ямаахай гуайн санаачилгаар “Цэвэршилтийн үеийн бэрхшээлийг ээнэгшүүлэх арга зам” сэдэвт сургалтыг явуулсан нь сургалт-мэдээллийн ажлыг төв байрандаа явуулах боломжтой болохыг харуулж байна.

МЭХ-ны Ерөнхий зөвлөлийн Ажлын алба өөрийн байртай болсон нь:

МЭХ-нд төр засгаас Үйлдвэрчин, залуучууд, хүүхдийн байгууллагын нэгэн адил байр гаргаж өгсөн байдаг. Л Пагмадулам даргын үед хотын захиргааны ар талд, одоогийн нийслэлийн өмчийн газар байрлаж байгаа байрыг өгч, МЭХ-ны төв аппарат байрлан үйл ажиллагаагаа явуулж байжээ. Гэвч дараагийн удирдлага болох Д Мөнхөө Засгийн газрын ордонд нүүж орох

шийдвэр гаргасан байдаг. Монгол улсад 1990 оноос бүтцийн өөрчлөлт хийгдэхэд МЭХ-ны төрийн чиг үүрэг үгүй болсноор улсын төсвөөс санхүүжих, төр засгийн байранд байрлах явдал хаагдаж, түрээсийн байранд шилжжээ. 1993 – 2008 оны хооронд МЭХ-ны Ерөнхий зөвлөлийн Ажлын алба байраа 7 удаа сольсон байдаг. Энэ нь түрээсийн төлбөр улам бүр өндөр болж байснаас үүдэлтэй юм. Жижиг зээлийн төслийн үр дүнгээс өөрийн гэсэн байр худалдан авах тухай холбооны дэд ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэгийн саналыг дэмжиж, 1997 онд 50 мянгатын 22-р байранд 3 өрөө байр авч зах зээлийн шинэ харилцааны үед анх удаа өөрийн гэсэн байртай болсон юм. Энэ байр нийтийн байрны захын орцын 3 дугаар давхарт байрлаж байсан нь тэр бүр гишүүд дэмжигчдийн санаанд нийцэхгүй байв. Тиймээс бага тойруу дахь банкны ажилчдын байрны 1-р давхарт сольж, шууд гаднаасаа орох үүдтэй болгожээ. МЭХ-ны удирдлагаас МЭХ-нд байшин бариулах зураг төслийг гаргуулж, МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нараар уламжлан хотын дарга М Энхболд, Батбаяр, Иргэдийн хурлын дарга Болормаа нараас газар хүссэн боловч дэмжлэг авч чадаагүй байдаг. Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн болон эдийн засгийн эрхийн хэрэгжилт, эмэгтэйчүүдийг чадавхижуулах зэрэг хөгжлийн асуудал жендэрийн үзэл баримтлалд дарагдан хариуцах эзэнгүй болсон жилүүдэд төр засаг бодлогоо барих байх хэмээн найдаж 2004, 2005 оны сонгуулиар тухайн үед Засгийн эрхийг барьж байсан МАХН-ыг дэмжиж ажилласан боловч тухайн үеийн удирдлага МЭХ-г монголын түүхийн нэг хэсэг бөгөөд төр засгийн бодлогоор дэмжиж ажиллах шаардлагыг ойшоож үзээгүй юм. Иймээс хотын төвд тусдаа байр худалдан авах боломжийг судалж, одоогийн Чингэлтэй дүүрэг дэх Самбуугийн гудамжны 3-ийн 11-д байртай болсон нь найм дахь нүүлт буюу өөрийн гэсэн ажлын байртай болсон явдал байв. Урд нь Ерөнхий зөвлөлийн хурал, сургалтуудаа аль нэг газарт төлбөртэйгөөр явуулдаг байсан бол одоо Чуулган болон төвлөрсөн томоохон арга хэмжээнээс бусад үйл ажиллагааг өөрийн байранд явуулдаг болжээ. Байруудыг шинэчлэх үндсэн хөрөнгийн хөдөлгөөнийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргасны үндсэн дээр хэрэгжүүлж байв.

Шинэ нөхцөлд МЭХ-ны гадаад харилцааг хөгжүүлсэн нь:

Улс төрийн ардчилал, эдийн засаг дахь либералчлал, зах зээлийн харилцааны шилжилтийн шинэ нөхцөл байдалд МЭХ-ны гадаад харилцааг шинээр тогтоох хэрэгтэй болсон юм. Учир нь хуучин социалист улс орнуудын хооронд байсан харилцааг дагасан холбооны гадаад үйл ажиллагаа нэг хэсэгтээ зогсов. ОУАЭХ болон ЗХУ задарсны дараа бүрэлдэн бий болсон улс орнуудаас ямар нэгэн сураг чимээ алга байлаа. Харин НҮБ-ын салбарын болон төрөлжсөн байгууллагууд Монгол улсад идэвхитэй ажиллаж эдгээр байгууллагуудын шугамаар олон тооны гадаад арга хэмжээнд оролцож, техник санхүүгийн дэмжлэгээр нь олон тооны төсөл хэрэгжүүлэх болов.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сангийн “Жижиг зээл ба эмэгтэйчүүд” семинар 1994 онд Йемений нийслэлд энэ улсын Гүнжийн ивээл дор болоход МЭХ-ны дэд ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэг оролцож, жижиг зээлийн төслийн тайлангаа тавьсан юм. Энэ үед жижиг зээлийн эргэн төлөлт 100 хувьтай, маш амжилттай хэрэгжиж байсан тул МЭХ дараа дараагийн олон жижиг зээлийн төслийн санхүүжилт олж авсан байна.

Сингапур улсад Зүүн ба зүүн өмнөд Азийн эмэгтэйчүүдийн Чуулга уулзалт 1994 онд болж Дэлхийн эмэгтэйчүүдийн 4-р бага хуралд тус бүс нутгийн эмэгтэйчүүдийн байгууллагаас оруулах асуудлаар санал солилцоход МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, Хатагтай нарын нийгэмлэгийн тэргүүн Балжинням нар оролцсон бөгөөд “Монгол улсад өрнөсөн ардчилал шинэчлэл ба эмэгтэйчүүд” сэдвээр мэдээлэл хийв.

НҮБ-ын Ази номхон далайн бүсийн нийгэм эдийн засгийн хөгжлийн комиссоос зохион байгуулсан Бээжингийн бага хурал, иргэний нийгэм, ТББ-ын Чуулганы бэлтгэл ажилтай танилцах уулзалт Тайландын Бангкок хотноо болоход МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн ажилтан Олончимэг, Хатагтай нарын нийгэмлэгийн тэргүүн Балжинням нар оролцов. Тус уулзалт комиссын ажлын тайланг хэлэлцээд Бээжингийн арга хэмжээнд аль болох олон төлөөлөгч оролцуулах, тэдний замын зардлыг

хөнгөлөх асуудлаар санал солилцож, НҮБ болон бусад олон улсын байгууллагуудад хуралд оролцох эмэгтэйчүүдийг дэмжих асуудлаар санал дэвшүүлсэн юм.

Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурал 1995 оны 9-р сарын 4-15-ны өдрүүдэд Бээжин хотноо хуралдав. Тус хурлыг НҮБ-аас зохион байгуулав. Бага хуралд Монголын засгийн газрын төлөөлөгчдийг НХХ-ийн сайд Э.Гомбожав тэргүүлсэн ба төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд НХХЯ-ны түшмэл Ж.Алтанцэцэг, Ерөнхийлөгчийн тамгын газрын ажилтан Алтангэрэл, УИХ-ын гишүүн Д.Мөнхөө, ГХЯ-ны ажилтан Ц.Нямсүрэн, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайд Цахилгаан, Монгол улсын тэргүүн хатагтай Ш.Цэвэлмаа, Архангай аймгийн ИХТ-ийн дарга бөгөөд МАХН-ын хорооны дарга Б.Шатар, НХХЯ-ны газрын дарга Энхжаргал, МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг, радиогийн сурвалжлагч Энхтуяа нар оролцов. Бага хурлаас Бээжингийн тунхаглал, “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр” гаргасан ба түүнийг НҮБ –ын Ассамблей хэлэлцэн баталсан болно. Бага хуралтай зэрэгцэн чуулсан ТББ-ын Чуулганд Монголоос 300 гаруй эмэгтэйчүүд оролцооны 283 төлөөлөгчийг МЭХ зохион байгуулж, зардал санхүүжилтийг нь олж явуулсан юм. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд МЭХ-ны Удирдах зөвлөлийн гишүүд, аймаг, хотын ЭЗ-ийн дарга нар, урлаг соёлын төлөөлөгчид, эмэгтэйчүүдийн гар урлалын үзэсгэлэн-худалдаа зохион байгуулагчид оролцсон болно. Энэхүү Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурал, ТББ-ын Чуулган нь манай эмэгтэйчүүдэд олон улсын эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөөс суралцах томоохон сургууль болсны зэрэгцээ улс орондоо хэрэгжүүлэх, нөлөөлөх ажлын маш тодорхой чиглэл гаргаж өгсөн билээ.

Зүүн ба Зүүн өмнөд Азийн эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн 2 дугаар ассамблей Филиппины Куалалампурт 1997 онд хуралдав. Тус хуралд МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, гадаад харилцааны ажилтан Олончимэг нар Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төвийн ажилтнуудын хамт оролцсон ба МЭХ-ноос НҮБХАСангийн тусламжтайгаар хэрэгжүүлж буй нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн төслийн явц, үр дүнгийн талаар илтгэл тавив. Тус Ассамблейн Удирдах зөвлөлд Малайз, Кампучи, Монгол, Филиппины эмэгтэйчүүдийн байгууллагын төлөөлөгчид орсны дотор МЭХ-ны ерөнхийлөгч Н. Гэрэлсүрэн сонгогджээ. Удирдах зөвлөлийн 2 дугаар хурлыг Тайланд 1998 онд хийхэд Н.Гэрэлсүрэн, холбооны гадаад харилцааны ажилтан Төгсбаяр нар, 3 дугаар хурал 1999 онд Кампучийн Пномпен хотод хуралдаж Н.Гэрэлсүрэн, төслийн ажилтан Б.Одончимэг нар оролцов. 4 дүгээр хурлыг Удлаанбаатар хот, Төв аймгийн Зуун мод хотод МЭХ зохион байгуулж “Эмэгтэйчүүдийн цэвэршилтийн үеийн онцлог, түүнийг өнгөрүүлэхэд эмэгтэйчүүдэд туслах нь “ асуудлыг хэлэлцсэн юм. Төв аймагт болсон хурлыг өргөтгөсөн байдлаар хийж, МЭХ-ны бүх гишүүн байгууллагын төлөөлөгчийг оролцуулан хэлэлцүүлэг-сургалт явуулсан байдаг нь урд өмнө тэр бүр яригдаж байгаагүй асуудлаар эмэгтэйчүүдэд ойлголт мэдлэг өгөхөд ихээхэн ач холбогдолтой болсон юм.

Японы Токио хотод 1997 онд зохион байгуулсан Зүүн ба зүүн өмнөд азийн бүсийн эмэгтэйчүүдийн уулзалтад МЭХ-ны Ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн ЛЭОС, Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны төлөөлөгчдийн хамт оролцов.

Ази Номхон далайн бүсийн эмэгтэйчүүдийн хөгжлийн төвөөс Сингапур улсад 1998 онд зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах нь” сэдэвт симпозиумд МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг нар оролцож, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар Монгол улсын засгийн газраас авч буй арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн байна.

Харин ОУАЭХ-ноос 1999 онд анхны сураг гарч, хуралдаа оролцохыг урьжээ. Францын нийслэл Париж хотноо хуралдсан ОУАЭХ-ны XII хуралд холбооны дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг төлөөлөгчөөр оролцов. Гэвч энэ хурлын индэр дээрээс зарим орны төлөөлөгчид Монгол улсын сонгож авсан ардчиллын зам, хамтын ажиллагаатай түншүүдийн талаар өөр үзэл баримтлалаа илэрхийлж байсан нь гишүүнчлэлээ сэргээх эсэх талаар нухацтай ярилцах хэрэгтэй болохыг харуулж байв. Түүний дараа дараагийн хурлуудад урилга ирж байсан боловч МЭХ санхүүгийн бэрхшээлээс болоод төлөөлөгч оролцуулаагүй юм. Харин 2009 оны 7 дугаар сард ОУАЭХ-ны Ази номхон далайн бүсийн бага хурал Хүнсний аюулгүй байдлын

асуудлаар Энэтхэг улсад хуралдахад холбооны ажилтан Ж Билэгдэмбэрэлийг ажиглагчаар оролцуулсан байна.

Тайландын Вант улсын эмэгтэйчүүдийн төлөөлөгч 10 гаруй хүнийг МЭХ хүлээн авч Монголын эмэгтэйчүүдийн байдал, үзэсгэлэнт байгальтай танилцах аялал зохион байгуулсан юм. Тайландын эмэгтэйчүүдийн байгууллагын урилгаар МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, дэд ерөнхийлөгч Ж. Эрдэнэчимэг ХШК-ын гишүүн Д.Ома, Удирдах зөвлөлийн гишүүн С. Саранцэцэг, Ё. Цоомоо нар бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид хариу зочилж, Тайландын эмэгтэйчүүдийн байгууллагын үйл ажиллагаатай танилцсан юм.

Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурлаас гаргасан мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний тухай “Бээжин +5” олон улсын бага хурлыг Нью-Йорк хотноо 2000 оны 6 дугаар сард НҮБ-аас зохион байгуулав. Тус бага хуралд Дэлхийн 100 гаруй орны төр засгийн тэргүүн, сайд нар, ТББ, иргэний нийгмийн төлөөлөгчид оролцов. Монгол улсаас Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Н. Туяа оролцож “Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Монгол улсын Засгийн газраас авсан арга хэмжээний тухай” илтгэл тавив. Монголын эмэгтэйчүүдийн ТББ-аас МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, ЭЯГБХУКХХТҮТ-ийн тэргүүн Ж.Занаа, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газрын төслийн зохицуулагч О. Оюунцэцэг, ЛЭОС-ын дэд тэргүүн Одончимэг нар оролцжээ. Бага хурлын зэрэгцээ Иргэний нийгмийн чуулга уулзалт болж, эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудал болох ДОХ, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүн худалдахын эсрэг тэмцэх, эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллуулах, охидын зэрэг олон асуудлаар салбар хуралдаан хийжээ. Бээжингийн тунхаглалд охидын асуудал орхигдсон байсныг нэмж оруулан “Бээжин+5” тунхаглалыг баталсан байдаг. Монголоос оролцсон төлөөлөгчид Монгол улсын хөтөлбөрт мөн охидын асуудлыг тусгах санал дэвшүүлэн шийдвэрлүүлсэн болно.

Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурал, Иргэний нийгмийн Чуулга уулзалтын 10 жилийн ойг тохиолдуулан НҮБ, БНХАУ-ын Засгийн газраас “Бүх нийтийн хөгжлийн төлөө жэндэрийн тэгш эрхийг бэхжүүлэх нь” сэдэвт бага хурлыг 2005 онд Бээжин хотноо зохион байгуулав. Тус бага хуралд дэлхийн 90 гаруй улсын төр засгийн удирдагчид, НҮБ-ын албаны хүмүүс, иргэний нийгмийн төлөөлөгчид 1000 гаруй хүн оролцов. Монголоос тус бага хуралд МЭХ-ны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд МЭХ-ны удирдах зөвлөлийн гишүүн “Онсь трейд” ХКК-ийн захирал Ж. Маралмаа, МЭХ-ны удирдах зөвлөлийн гишүүн “Хатагтай инвест” ХХК-ийн захирал С. Саранцэцэг, МЭХ-ны удирдах зөвлөлийн гишүүн Улаанбаатар хотын ЭЗ-ийн дарга П.Алтанцэцэг, ТВ-5 телевизийн сурвалжлагч Доржбат нар байв. Бага хурлыг нээж БНХАУ-ын Ерөнхийлөгч Ху Жин Тао үг хэлсэн бөгөөд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга дарга Кофи Аннан илгээлт явуулсныг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөх хатагтай Лоус Арбор уншиж танилцуулав. Тус бага хуралд 50 гаруй орны тэргүүн, парламентч эмэгтэйчүүд үг хэлэв. Мөн эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлуудаар салбар хуралдааныг хийж, “Бээжин +10” тунхаглалыг батлав. Тунхаглалд Бээжингийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн дагуу дэлхийн эмэгтэйчүүдийн хөгжилд ихээхэн амжилт гарсныг тэмдэглээд уг хөтөлбөрийг Мянган тунхаглал, Мянган хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг бүх орнуудын Засгийн газар, ТББ-дад уриалжээ. Хурлын үер “Хятадын эмэгтэйчүүдийн хөгжил ба 10 жилийн дэвшил” нэртэй үзэсгэлэн гаргаж, дэлхийн олон орны эмэгтэйчүүдэд хятадын эмэгтэйчүүдийн ололт амжилтыг сурталчлав. Мөн эмэгтэйчүүдийн гар урлал, бүтээгдэхүүний үзэсгэлэн - худалдаа ажиллуулсан байна.

Япон улсын иргэн Фужимото Тодаши, Фужимота Микико нар 1990 онд Монгол улсад жуулчны шугамаар ирэхдээ өөрсдийн хүсэлтээр МЭХ-ны дарга Д.Мөнхөөтэй уулзаж Монголын эмэгтэйчүүд, хүүхдийн байдалтай танилцаад тэдэнд туслах сайхан санаачилга гаргасан нь ажил болж манай олон эмэгтэйчүүд тэдний тусламжаас хүртсэн юм. Тэд Япон-Монголын найрамдал, соёлоор харилцах “Солонго” нийгэмлэгийг байгуулж Монголын хүүхэд эмэгтэйчүүдэд туслах сая ширхэг саван, хувцас, хүнсний зүйл цуглуулан монголын эмэгтэйчүүдэд илгээх ажлыг зохион байгуулсан юм. “Солонго” нийгэмлэгийн цуглуулсан саванг Японы Засгийн газрын “Өвчний үндэс” төслөөс тээврийн зардлыг гарган ирүүлжээ. “Солонго” нийгэмлэг МЭХ, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Чингэлтэй дүүргийн Засаг даргын

Тамгын газар зэрэг харилцаатай байгууллагуудаасаа давхардсан тоогоор 10 гаруй хүнийг Японд урьж, Парламентийн ордон, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвүүд, хууль хяналтын болон соёлын байгууллагуудаар танилцах аялал зохион байгуулж байв. МЭХ тус нийгэмлэгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзалт, соёлын арга хэмжээ, байгалийн аялал зэргийг зохион байгуулж байв. Нийгэмлэгээс ирүүлсэн нэг сая савангийн 20 орчим хувийг хямд үнээр борлуулж, “Солонго” нийгэмлэг, “Алслан” клубээс хандивласан хөрөнгөтэй нийлүүлэн жижиг зээлийн сан байгуулсан ба тус сангийн хөрөнгөнөөс Амгалан дахь Эмэгтэйчүүдийн хөгжлийн төвд цахилгааны трансформатор, төмөр хашаа барьж, гүний худаг гаргуулжээ. Үлдэгдэл хөрөнгө болох 10 000 америк долларыг Чингэлтэй дүүргийн ЗДТГазарт шилжүүлж, 1997 онд тус дүүрэгт байгуулагдсан “Солонго” сургуулийг байгуулахад хандивлажээ.

Казахстаны Астана хотод 2006 оны 3-р сард Евро- Азийн эмэгтэйчүүдийн анх дугаар чуулган болж, “Эмэгтэйчүүд улс төрд”, “Эмэгтэйчүүд эдийн засаг-бизнесийн салбарт”, “Эмэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэнд, гэр бүлд гүйцэтгэх үүрэг”, “Эмэгтэйчүүдийн эрх” зэрэг асуудлыг хэлэлцэв. Энэхүү чуулганд 23 орны 360 төлөөлөгч оролцжээ. Монголын эмэгтэйчүүдийг төлөөлөн Баян-Өлгий аймгийн Эмэгтэйчүүдийн Зөвлөлийн дарга агсан Т. Саулетхан оролцож, “Эдийн засаг, бизнесийн салбарт монголын эмэгтэйчүүдийн оролцоо” сэдвээр мэдээлэл хийжээ. Төлөөлөгчдөд Казахстаны эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцооны талаар танилцуулсан байна. Энэ хурлыг цаашид 2 жил тутамд зохион байгуулж байхаар тогтож, 2 дугаар уулзалтыг Москва хотноо зохион байгуулах шийдвэр гаргажээ.

Улс орнуудын эмэгтэйчүүдийн байгууллагатай харилцаагаа сэргээсэн нь: БНХАУ-ын Бүх Хятадын Ардын хурлын орлогч дарга Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Холбооны дарга Чин Му Хагийн урилгаар 1997 онд МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, МЭХ-ны дэд ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг, МЭХ-ны ХШХ-ны дарга Б.Долгормаа, Хүчирхийлэлийн эсрэг үндэсний төвийн ерөнхийлөгч, Монголын эмэгтэйчүүдийн хорооны орлогч дарга асан Ж.Алтанцэцэг, МЭХ-ны Сургалт-үйлдвэрлэлийн төвийн эрхлэгч С.Хандмаа нар албан ёсны айлчлал хийжээ. Төлөөлөгчид Бүх Хятадын эмэгтэйчүүдийн хороо, Бээжин, Нанжин, Фужей, Шамин хотуудын эмэгтэйчүүдийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцжээ.

БНВУ-ын эмэгтэйчүүдийн байгууллагатай тогтоосон уламжлалт харилцаа 1990 оноос хойш хэсэг зогсонги байсан боловч 1997 онд МЭХ-нд Вьетнамын эмэгтэйчүүдийн байгууллагаас урилга ирж, Вьетнамын эмэгтэйчүүдийн 8 дугаар Их хуралд МЭХ-ны ерөнхийлөгч Н.Гэрэлсүрэн, “Эмэгтэйчүүд-хөгжил хөдөлгөөн”-ий тэргүүн Д. Алтай нар оролцжээ. Хурал Вьетнамын Эмэгтэйчүүдийн холбооны тайлант хугацааны ажил, цаашдын зорилтын тухай хэлэлцэж шийдвэр гаргасан бөгөөд Монголын төлөөлөгчдийн нэрийн өмнөөс МЭХ-ны ерөнхийлөгч Н. Гэрэлсүрэн хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч талархалын үг хэлэхдээ хоёр орны эмэгтэйчүүдийн байгууллагын хамтын ажиллагаа, харилцааг шинэ нөхцөл, шаардлагад нийцүүлэн улам хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэсэн байна. Хурлын дараагаар төлөөлөгчид Вьетнамын эмэгтэйчүүдийн байгууллагад албан ёсны айлчлал хийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн дунд зохиож буй ажил, сургалт - судалгааны төвийн болон олон улсын байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаатай танилцжээ. Мөн Вьетнамын эмэгтэйчүүдийн байгууллагын идэвхтэн сонгуультагнуудад монголын эмэгтэйчүүдийн байгууллагуудын үйл ажиллагааны тухай мэдээлэл хийв. Айчлалын явцад хоёр талын эмэгтэйчүүдийн байгууллагын хамтын ажиллагааны талаар ярилцаж харилцан мэдээлэл солилцож байхаар тохирчээ. 2003 онд Вьетнамын эмэгтэйчүүдийн 9 дүгээр Их хуралд МЭХ-ны ерөнхийлөгч Ж. Эрдэнэчимэг, УЗ-ийн гишүүн Циенхүү нар урилгаар оролцсон бөгөөд хурлын дараа болсон ОУАЭХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн хуралд ажиглагчаар оролцжээ.

Ийнхүү 90-ээд оноос хойш МЭХ-ны гадаад харилцаа илүү өргөн бөгөөд олон талтай болж ирсэн юм. Гадаад харилцааны арга хэмжээг товчлон сийрүүлбэл,

Он	Үйл ажиллагаа:
1998	<ul style="list-style-type: none"> - Япон –Монголын соёлын харилцааны Солонго нийгэмлэгийн тэргүүн, хатагтай Фужимотог хүлээн авч уулзав. - Австралийн Бээжин дэх ЭСЯ-ны ажилтан хатагтай Жүди Лоиг хүлээн авч

	<p>уулзав</p> <ul style="list-style-type: none"> - МЭХ-ны ерөнхийлөгч Н Гэрэлсүрэн “Амжилттай туршлагыг дэлгэрүүлэхүй” төслийн үр дүнг хэлэлцэх олон улсын хуралд оролцов. - Монгол улс дахь БНХАУ-ын Элчин сайдын гэргийг хүлээн авч уулзав. - МЭХ-ны ажилтан Д Байгалмаа Япон улстай танилцах аялалд оролцов - МЭХ-ны хэвлэлийн ажилтан Ц Наранцэцэг Бангкокт “Иргэний нийгэм-эмэгтэйчүүдийн оролцоо” Чуулганд оролцов
1999	<ul style="list-style-type: none"> - Английн хоршооллын байгууллагын төлөөлөгчдийн хүлээн авч уулзав - Бахай эмэгтэйчүүдийн нийгэмлэгийн тэргүүн хатагтай Тахираг хүлээн авч уулзав - Норвегийн парламентийн төлөөлөгчид МЭХ-ны хэрэгжүүлж буй төсөлтэй танилцав - НҮБЭХСангийн тэргүүн, хатагтай Ноелин Хейзерийг хүлээн авч уулзав. - Японы Зонта клубын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. - Японы бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөгчидтэй уулзав. - Дэлхийн банкны төлөөлөгч Рене Массэг хүлээн авч уулзав. - Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. - Лос Анжелес таймс сонины сүтгүүлч Робин Брайтийг хүлээн авч уулзав.
2000	<ul style="list-style-type: none"> - Эрхүүгийн эмэгтэйчүүдийн “Анкара” байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. - Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Дорно Дорно” хөтөлбөрийн захирал хатагтай мариятай уулзав - Японы Энх тайван найрамдлын нийгэмлэгийн төлөөлөгчдийг хүлээн авав - Канадын “жижиг технологи” төслийн боловсролын зөвлөх хатагтай Саша Иннесийг хүлээн авч уулзав
2001	<ul style="list-style-type: none"> - АНУ-ын “Америкийн эмэгтэйчүүд харилцан ойлголцлын төлөө” байгууллагын төлөөлөгч хатагтай Роберт Картер тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авав - ТАСИС хөтөлбөрийн мэргэжилтэн хатагтай Анна Мауро, ноён Мауро Хавер нарыг хүлээн авч уулзав
2002	<ul style="list-style-type: none"> - НҮБХХ-ийн ДОХ-ын хөтөлбөрийн мэрэгжилтнүүдтэй уулзав - Монгол дахь Вьетнамын ЭСЯ-ны ажилтнуудыг хүлээн авч уулзав. - Италийн ГХЯамны Азийн орнуудыг хариуцсан мэргэжилтэн хатагтай Биондиг хүлээн авч уулзав - Азийн хөгжлийн банкны ажилтан хатагтай Лизаг хүлээн авч уулзав - Австралийн Залуу амбан сайд хөтөлбөрийн хүрээнд сайн дурын ажилтан Клаудия хэйсийг нэг жилийн хугацаатай авч ажиллуулав. - Японы Азийн эмэгтэйчүүдийн судалгааны төвийн төлөөлөгчдийг хүлээн авав. - Өмнөд Солонгосын сайн дурын нийгэмлэгийн шугамаар багш нарыг хүлээн авав. - Дэлхийн банкны ядуурлыг бууруулах хөтөлбөрийн үнэлгээний багийн мэргэжилтнүүдийг хүлээн авч уулзав. - ХААХОУСангийн мэргэжилтнүүдийг хүлээн авч уулзав. - Энэтхэгийн эмэгтэйчүүдийн их хуралд холбооны ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэг, УЗ-ийн гишүүн Циенхүү нар оролцов.
2003	<ul style="list-style-type: none"> - Солонгосын “Зорилготой залуус” байгууллагын төлөөлөгчдийг хүлээн авав. - МЭХ-ны Монголжингоо сонины сурвалжлагч ш ариунаа Япон улсад болсон “Эмэгтэйчүүдийн мэдээлэл” сэдэвт олон улсын чуулганд оролцов. - ЖАЙКА ба АPROTECH байгууллагын шугамаар Филиппин улсад болсон “Органик фермийн аж ахуй ба эрүүл аж төрөх нь” сэдэвт семинарт холбооны ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэг оролцов.
2004 - 2009	<ul style="list-style-type: none"> - Азийн бүтээмжийн төвөөс Япон, Солонгос улсад зохион байгуулсан ХАА-д ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудлаарх семинарт холбооны

	<p>ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэг оролцож, монголын байдлын талаар илтгэл тавив</p> <ul style="list-style-type: none"> - ЖАЙКА ба АPROTECH байгууллагын шугамаар Филиппин улсад болсон “Ногоон ургамал ба эрүүл аж төрөх нь” сэдэвт семинарт МЭХ-ны УЗ-ийн гишүүн Ж Маралмаа оролцов. - Будапешт хотноо болсон жижиг зээлийн олон улсын семинарт холбооны ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэг оролцов. - МУЗГ, ХААХОУСангийн хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн “Эмэгтэйчүүдийн хөгжил” дэд хэсгийг хэрэгжүүлж, МЭХ-ны ажилтан Т Гүндэгмаа, төслийг хэрэгжүүлэгч аймгийн ЭЗ-ийн дарга нар Энэтхэг улсад танилцах дадлага хийв. - Дэлхийн эмэгтэйчүүдийн дээд хэмжээний уулзалт Вьетнамын нийслэл Ханой хотод болоход монголоос 22 эмэгтэйчүүдийн төлөөлөгчдийг оролцуулав.
--	---

МЭХ-ны хэвлэлийг шинэ нөхцөлд ажиллуулсан нь:

МЭХ 1990-1994 онд “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийн нэрийг “Гоо марал” нэртэй болгон гаргажээ. Энэ үед сэтгүүлийн эрхлэгчээр Бя.Энхтуяа ажиллажээ. “Гоо марал” сэтгүүл 1993 оноос хавсралт “Монголжингоо” сонинтой болсон нь тухайн үеийн санхүүжилтийн эх үүсвэр нь сэтгүүл гаргаж чадахгүйтэй холбоотой байв. “Монголжингоо” сонин ч алдаг оног гарч байжээ. Хөрөнгө санхүүгийн асуудлаас болоод МЭХ-ноос тусдаа гарсан энэ сэтгүүлийн газар өөрийн гэсэн байргүйгээс “Үнэн” сонины шатан дор сандал, ширээгээ хураагаад гадуур ажилладаг болсон байв. 1993 онд сонгогдсон МЭХ-ны шинэ удирдлага тэднийг өөрийн байрандаа оруулж, хэвлэх үйлдвэрт тавьсан хагас сая гаруй төгрөгийн өрийг нь төлөөд, үйл ажиллагаа явуулах боломжоор хангасан байдаг. Бя.Энхтуяа өөрийн саналаар сэтгүүлийн эрхлэгчийн ажлыг өгч, холбооны дэд ерөнхийлөгч Ж Эрдэнэчимэгт хэвлэлийн эрхлэгчийг хавсруулан ажиллуулжээ. Ийнхүү 1995 оноос одоог хүртэл “Монголжингоо” сонин сар тутам хэвлэгдэн улсын захиалга болон холбооны дотоод сүлжээгээр эмэгтэйчүүдэд мэдээлэл хүргэж байна. “Монголжингоо” сонины сэтгүүлч, эх бэлтгэгч, хэвлэлийн албаны даргаар 1994 оноос одоог хүртэл Нацагням, Г. Ариунаа, Ж. Батсайхан, Амаржаргал, Д.Наранцэцэг, Ш Ариунаа, Г Ганчимэг нар ээлжлэн ажиллаж иржээ.

Монголжингоо сонин эмэгтэйчүүдийн эрх чөлөөний индэр – хэвлэн нийтлэх эрхийн залгамж холбоо, эмэгтэйчүүдийн байгууллагын идэвхитэн сонгуультны гарын авлага болж, олон тооны тогтмол булантай, нийгмийн тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцож, холбооны үйл ажиллагааг мэдээлдэг эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, хэвлэлийн түүхийн нэг хэсэг байсаар байна. Зах зээлийн эхэн үеийн цаг зуурын бэрхшээлээс үүдсэн сөрөг хандлага сонин хэвлэлийн нийтлэлийн бодлогод тусгалаа олж, гүтгэлэг хардлага, садар самуун, хэрүүл маргааны талбар болж байсан он жилүүдэд эмэгтэйчүүдийн хэвлэл ёс зүй, гэгээн суртлаа алдаагүй, орлого хөөж, сугалаагаар зарагдахад хүрээгүй, ухаарал гэгээрлийн бага ч болов очийг хүмүүний оюунд хүргэхийн төлөө хаалга барилгүй 85 жилийн ойтойгоо золгох гэж байна.

МЭХ, Монголын радиотай хамтран 1997 – 2000 онд, эмэгтэйчүүдэд зориулсан “Бэр цэцэг” нэвтрүүлэг, 2003 оноос ХЯБХ-ийн шугамаар “Эмэгтэйчүүдийн хөгжил” нэвтрүүлгийг орон даяар явуулж иржээ. Нэвтрүүлэг бэлтгэх ажлыг Монголын радиогийн ажилтан Сосорбарам, Мөнхбаяр, Баясгалан нарын зэрэг хүмүүс хийж байв. Ийнхүү МЭХ, түүний гишүүн байгууллагууд эмэгтэйчүүдэд мэдээлэл хүргэх ажилд анхаарал хандуулж, төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй нягт хамтран ажиллаж ирсэн юм.

Олон нийтийн төвлөрсөн арга хэмжээг зохион байгуулсан нь:

МЭХ-ны Удирдах зөвлөл, гишүүд дэмжигчдээс санаачлан шинэлэг хэлбэрийн олон нийтийн төвлөрсөн арга хэмжээ зохион байгуулж ирсний жишээ нь “Монгол улсын оны шилдэг бизнес эмэгтэй” шалгаруулах явдал юм. Энэ арга хэмжээг ТВ-5 телевизтэй хамтран жил бүр зохион байгуулж байна. Мөн ТВ-9 телевиз, “Эмэгтэйчүүд – эв нэгдэл” ТББ-тай хамтран “Нийгмийн зүтгэлтэн-Шилдэг эмэгтэй”-г тодруулан алдаршуулах ажил уламжлал болон хийгдэж байна. Жил бүрийн Мартын 8-ныг тохиолдуулан МЭХ-ны Хүндэт өргөмжлөлт ээжүүдийг урамшуулдаг

болжээ. Шинэ нөхцөлд, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулсан томоохон арга хэмжээ бол Монголын эмэгтэйчүүдийн анхдугаар нэгдсэн Чуулганыг зохион байгуулсан явдал байв.

Монголын эмэгтэйчүүдийн Анхдугаар нэгдсэн Чуулган: Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан 2006 оны 3-р сарын 24-ны өдөр Монголын Эмэгтэйчүүдийн Анхдугаар Нэгдсэн Чуулган /МЭАНЧ/ -ыг МЭХ-ны Удирдөх зөвлөлөөс нийслэл хотноо Улаанбаатар Паласын концертын их танхимд зохион байгуулав. Чуулганд манай орны аймаг, сум, хот, дүүрэг бүрээс 3000 шахам эмчүүд, эмэгтэйчүүдийн төлөөлөгчид өөрсдийн хүсэл тэмүүлэлээр ирж оролцов. Энэ нь Монголын эмэгтэйчүүдийн байгууллагын түүхэнд хамгийн олон төлөөлөгч оролцуулсан Чуулган болсон юм. Чуулганы ажиллагаа нь манай эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх өндөр байгааг харуулсны зэрэгцээ тэднийг зөв зохион байгуулж чадвал асар их нөөц хүч байгааг илтгэн харуулсан юм. Чуулганаар МЭХ-ны ерөнхийлөгч Ж.Эрдэнэчимэгийн “Эмэгтэйчүүд ба хөгжил” , “Их хатадын ухаан- Анд нөхдийн холбоо” ТББ-ын тэргүүн Я.Урансайханы “Монголын түүхэнд их хатадын гүйцэтгэсэн үүрэг” сэдэвт илтгэлүүдийг хэлэлцэж “Монголын Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан байна. Энэхүү Хөтөлбөр нь эзэн богд Чингэсийн сургаалаас ишлэл авч, эмэгтэй хүн бүр ажиллаж, амьдарч байгаа орчиндоо хэрэгжүүлж үлгэрлэх арга ажиллагааг багтаан зааснаараа өмнөх хөтөлбөрүүдээс онцлог, жинхэнэ ёс зүйн баримт бичиг болсон байна. Чуулганаас монголын эмэгтэйчүүд 3 жил тутамд нэгдэн чуулж, нийгмийн тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцон төр засагтаа уламжилж байхаар тогтжээ. Чуулганд Монгол улсын Ерөнхийлөгч илгээлт ирүүлж, Ерөнхий сайд өөрийн биеэр оролцон үг хэлсэн ба УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Т Ганди, Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хорооны дэд дарга Б.Долгор нар эмэгтэйчүүдэд хандан үг хэлэв. Чуулганы төлөөлөгчдөд урлагийн эмэгтэй гавъятнуудын концерт тоглож үзүүлжээ.

Монголын эмэгтэйчүүдийн хоёрдугаар нэгдсэн Чуулган: МЭХ-ны Удирдах зөвлөлөөс Монгол улсад эмэгтэйчүүдийн байгууллага үүссэний 85 жилийн ойг тохиолдуулан Монголын эмэгтэйчүүдийн хоёрдугаар нэгдсэн Чуулганыг 2009 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр нийслэл Улаанбаатар хотноо Соёлын Төв өргөөнд зохион байгуулав. Чуулганаар Хүнсний ба Байгал орчны аюулгүй байдалд эмэгтэйчүүдийн иргэний нийгмийн байгууллагаас хийсэн хяналт-үнэлгээний дүнг хэлэлцэж, Зөвлөмж гаргасан байна. Чуулганд улс орны өнцөг булан бүрээс 1000 гаруй эмэгтэйчүүдийн төлөөлөгч оролцжээ. Хүний зүй бус ажиллагаа, ашиглалтын улмаас ариун онгон байгал: ой мод, хөрс шороо, гол горхи, агаар ус бохирдон эвдэрч, эрүүл хүнс үйлдвэрлэх үндэсний чадамж буурснаас хүнс хоол тэжээлийн баталгаат байдал алдагдаж, хүний эрүүл амьдрах эрхийн хэрэгжилтид аюул нүүрлэж байгааг анхааруулж, энэ талаар төр засаг, иргэний нийгэм хамтран ажиллах, авах арга хэмжээний тухай ажил хэрэгч санал боловсруулсан байна.